



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

(2019 оны эхний хагас жил)

2019.07.03
Улаанбаатар хот

**ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ – ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
2019 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

(2019 оны эхний хагас жил)

2019.07.03

Улаанбаатар хот

Стратегийн зорилт, хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		Хариуцах нэгж, албан тушаалтны нэр	Хэрэгжилтийн мэдээлэл, Хүрсэн түвшин (Шалгуур үзүүлэлтээр), Хэрэгжилтийн хувь
	Арга хэмжээний шалгуур үзүүлэлт (тоо, чанар хугацаа)-ийн хүрэх түвшин	Хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин		
1	2	3	5	6
<p>Нэг. “Төрийн өмчийн талаар хууль тогтоомж, бодлого, чиглэл, баримт бичгийн төсөл боловсруулах, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн засаглалыг сайжруулах удирдлага, зохион байгуулалтаар хангах” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</p>				
<p>ХӨТӨЛБӨР I</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хууль, эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгож, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах” хөтөлбөрийн хүрээнд:</p>				
<p>Арга хэмжээ 1.1.1 (1)</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль тогтоомж, журам, дүрэм, бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулалтыг сайжруулах, батлуулах; - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсаны дараа шаардлагатай эрх зүйн актын төсөл боловсруулах; - Холбогдох байгууллагаас төсөлд санал авах, байгууллагын цахим хуудас болон дотоод сүлжээнд байршуулж, олон нийт болон албан 	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн талаарх хууль, эрх зүйн орчин боловсронгуй болсон байна.</p>	<p>Захиргаа, хууль зүйн хэлтэс (Цаашид “ЗХЗХ” гэх),</p> <p>Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Цаашид “БТУХ” гэх),</p> <p>Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, хуулийн төсөл болон үзэл баримтлалын төслийг боловсруулан холбогдох баримт материалын хамт Ерөнхий сайд болон ЗГХЭГ-ын даргад ТӨБЗГ-ын 2019 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А-1/1252 дугаартай албан бичгээр хүргүүлсэн бөгөөд ЗГХЭГ-аас өгсөн чиглэлийн дагуу хуулийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулж, төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулан ЗГХЭГ-т хүргүүлэв.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан дагалдах хуулиудад өөрчлөлт оруулах асуудлыг боловсруулсан.</p> <p>ТӨБЗГ-ын үндсэн болон дотоод үйл ажиллагаанд мөрдөж байгаа дараах журам, зааврыг боловсронгуй болгох ажлыг хийж байна:</p> <ul style="list-style-type: none"> – “Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”; – “Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгөд оруулах хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох, хяналт тавих, хүлээн авах, тооцож

	<p>хаагчдаас санал авах;</p> <ul style="list-style-type: none"> - Холбогдох байгууллага, албан хаагчдаас ирүүлсэн саналыг нэгтгэн судалж, үндэслэл бүхий саналыг төсөлд тусгах; - Төслийг газрын хуралдаан, даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, батлуулах; - Зарим төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх, батлуулах арга хэмжээ авах; - Жилдээ. 		(Цаашид “ТӨБХХ” гэх)	<p>баталгаажуулах ажлыг зохион байгуулах журам”;</p> <ul style="list-style-type: none"> – “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”; – “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам”; – “Түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар”; – ТӨБЗГ-ын 2016 оны “Дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 128 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах; – “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг”; – “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”; – “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”. <p>Эдгээрээс дор дурдсан журам, зааврууд батлагдаад байна:</p> <ul style="list-style-type: none"> – “Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам” (ТӨБЗГ-ын 2019 оны 260 дугаар тогтоолоор); – “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” тогтоол (Дуудлага худалдаатай холбоотой, ТӨБЗГ-ын 2019 оны 269 дүгээр тогтоолоор); – “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах арга хэмжээний тухай” тогтоол (ТӨБЗГ-ын 2019 оны 268 дугаар тогтоолоор); – “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам” (ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор); – “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам” (ТӨБЗГ-ын даргын 2019 оны А/163 дугаар тушаалаар). <p>Мөн “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын шинэчилсэн найруулгын төсөлд ЗГХЭГ-аас өгсөн чиглэлийн дагуу Засгийн газрын гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналыг судлан үзэж, зарим саналыг тусган журмын төслийг шинэчлэн боловсруулаад байна. (Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 1.1.2 (2) Төрийн өмчийн</p>	<p>- Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдэд удирдамж болон</p>	<p>Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх</p>	<p>БТУХ</p>	<p>Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдэд удирдамж болон заавар өгөх, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийн</p>

<p>төлөөллийг хэрэгжүүлэх этгээдэд удирдамж болон заавар өгөх, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийн ажлын тайлан, төлөөлөл хэрэгжүүлсэн байдлыг дүгнэх журам боловсруулах, батлуулах</p>	<p>заавар өгөх, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийн ажлын тайлан, төлөөлөл хэрэгжүүлсэн байдлыг дүгнэх журмын төслийг боловсруулах;</p> <ul style="list-style-type: none"> - Холбогдох хэлтсээс санал авах; - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, батлуулах; - I-IV улиралд. 	<p>этгээдэд удирдамж болон заавар өгөх, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх этгээдийн ажлын тайлан, төлөөлөл хэрэгжүүлсэн байдлыг дүгнэх эрх зүйн орчин боловсронгуй болсон байна.</p>		<p>ажлын тайлан, төлөөлөл хэрэгжүүлсэн байдлыг дүгнэх журмын төслийг боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлсэн. ЗГХЭГ-аас яамдын саналыг авч дахин боловсруулах чиглэлийг өгсөн. Журмын төсөлд яамдын саналыг тусган Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн боловч Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдах асуудалтай холбоотойгоор хойшлоод байна.</p> <p>Уг журмын төслийг боловсруулах асуудлаар “Компанийн засаглалын хөгжлийн төв” төрийн бус байгууллагатай санал солилцох уулзалтыг 6 дугаар сард хийсэн. (Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 1.1.3 (3)</p> <p>“Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг шинэчлэн боловсруулах, батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> - “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг захиргааны байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр шинэчлэн боловсруулах; - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулах, хэлэлцүүлэх, батлуулах; - I-II улиралд. 	<p>Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх эрх зүйн орчин боловсронгуй болсон байна.</p>	<p>БТУХ</p>	<p>“Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ыг боловсронгуй болгох асуудлыг судлан журмын төслийг боловсруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэн хуралдааны тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын дагуу зарим заалт, хэсгийг дахин боловсруулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 260 дугаар тогтоолоор шинэчлэн батлуулсан. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p>Арга хэмжээ 1.1.4 (4)</p> <p>Компанийн удирдлагын цалин хөлс, урамшууллын тогтолцоог компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний биелэлт,</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчит компанийн удирдлагын цалин хөлс, урамшууллын нэгдсэн судалгааг гаргах; - Төрийн өмчит компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний биелэлт, 	<p>Компанийн удирдлага, ажиллагсдын цалин хөлс, урамшууллыг үндэслэлтэй тооцох боломж бүрдсэн байна.</p>	<p>БТУХ</p>	<p>Компанийн удирдлагын цалин хөлс, урамшууллын тогтолцоог компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний биелэлт, ашигт ажиллагаа, улсын төсөвт төвлөрүүлсэн ногдол ашигт тулгуурлан тооцох аргачлалыг ТӨБЗГ-ын 2019 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар болон төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын 3 дугаар хавсралтад тодорхой зааж, уг журмыг мөрдүүлэх арга хэмжээ аван ажиллаж байна.</p>

<p>төлөвлөгөөний биелэлт, ашигт ажиллагаа, төрд төлсөн ногдол ашигт тулгуурлан тооцох аргачлал боловсруулах, батлуулах</p>	<p>ашигт ажиллагаа, төрд төлсөн ногдол ашгийн нэгдсэн судалгаа хийх;</p> <ul style="list-style-type: none"> - Компанийн удирдлагын цалин хөлс, урамшууллыг тооцоо судалгаанд тулгуурлан тооцох аргачлалын төсөл боловсруулах; - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулах, хэлэлцүүлэх, батлуулах; - I-IV улиралд. 			<p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p>Арга хэмжээ 1.1.5 (5)</p> <p>Төрийн өмчийг 2019-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн төсөл боловсруулах, батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчийг 2019-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах асуудлаар судалгаа хийх; - Төрийн өмчийг 2019-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийн төсөл боловсруулах; - Төслийг Засгийн газарт хүргүүлэх, батлуулах; - I улиралд. 	<p>Төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл тодорхой болсон байна.</p>	<p>БТУХ</p>	<p>ТӨБЗГ-аас 2018 онд “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Ерөнхий сайд, Засгийн газарт 2018 оны 03 дугаар сарын 21-нд хүргүүлсэн. Тус төслийг тухайн үед Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд 23 хуулийн этгээдийг бүрэн хувьчлах, 4 хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулах, нийт 27 хуулийн этгээдийг хувьчлах саналыг Улсын Их Хуралд 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн ЗГ-1/112 дугаар албан бичгээр өргөн барьсан. Улсын Их Хурлаас саналыг хэлэлцээд Эдийн засгийн байнгын хорооны дэргэд дэд ажлын хэсэг байгуулан дахин нарийвчлан судлахыг даалгасан. Уг ажлын хэсэгт ТӨБЗГ-аас холбогдох мэдээллийг гаргаж өгсөн.</p> <p>Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлээр Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг эгүүлэн татах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан. (Хэрэгжээгүй – 0%)</p>
<p>Арга хэмжээ 1.1.6 (6)</p> <p>2019-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн</p>	<ul style="list-style-type: none"> - 2019-2020 онд хувьчлах, өөрчлөн байгуулах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жагсаалтын төсөл боловсруулах; 	<p>Хувьчлах, өөрчлөн байгуулах хуулийн этгээдийн жагсаалт батлагдсан</p>	<p>БТУХ</p>	<p>ТӨБЗГ-аас 2018 онд “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, Ерөнхий сайд, Засгийн газарт 2018 оны 03 дугаар сарын 21-нд хүргүүлсэн. Тус төслийг тухайн үед Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд 23 хуулийн этгээдийг бүрэн хувьчлах, 4 хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувь хэмжээг бууруулах, нийт 27 хуулийн этгээдийг хувьчлах саналыг Улсын Их Хуралд 2018 оны</p>

<p>этгээдийн жагсаалт батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Засгийн газарт хүргүүлэх, батлуулах; - I улиралд. 	<p>байна.</p>		<p>05 дугаар сарын 29-ний өдрийн ЗГ-1/112 дугаар албан бичгээр өргөн барьсан. Улсын Их Хурлаас саналыг хэлэлцээд Эдийн засгийн байнгын хорооны дэргэд дэд ажлын хэсэг байгуулан дахин нарийвчлан судлахыг даалгасан. Уг ажлын хэсэгт ТӨБЗГ-аас холбогдох мэдээллийг гаргаж өгсөн.</p> <p>Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлээр Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг эгүүлэн татах нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан. (Хэрэгжээгүй – 0%)</p>
<p>Арга хэмжээ 1.1.7 (7)</p> <p>Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг шинэчлэн батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн талаар холбогдох судалгаа, шинжилгээ хийх; - Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтын төслийг боловсруулах; - Төслийг Засгийн газарт хүргүүлэх, шийдвэрлүүлэх; - I-IV улиралд. 	<p>Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтыг шинэчлэн батлуулсан байна.</p>	<p>БТУХ</p>	<p>Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн талаар судалгаа, шинжилгээ хийсний үндсэн дээр тогтоолын төслийг боловсруулан холбогдох яамдаас санал авч Засгийн газарт хүргүүлсэн. Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэлтэй зөрчилдөж байгаа тул үндсэн чиглэл батлуулсны дараа дахин боловсруулж шийдвэрлүүлэх чиглэлийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга өгч хойшлуулсан. Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдааны 22 дугаар тэмдэглэлээр Улсын Их Хурлын “Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай” тогтоолын төслийг эгүүлэн татах нь зүйтэй гэсэн шийдвэр гарсан тул Төрийн өмчөөс хувьчилж үл болох эд хөрөнгийн жагсаалтын төслийг эдийн засаг, нийгмийн өнөөгийн байдлыг харгалзан дахин боловсруулж, танилцуулахаар ажиллаж байна. (Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй – ХБ.)</p>
<p>Арга хэмжээ 1.1.8 (8)</p> <p>Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн маргаантай асуудлаарх Ерөнхий сайдын томилсон Ажлын хэсгийн ажлыг зохион байгуулах, Дэд ажлын хэсгийг ажиллуулах, холбогдох судалгаа, тооцоог хийх, ТӨБЗГ-ын саналыг бэлтгэх</p>	<ul style="list-style-type: none"> - Холбогдох тооцоо, судалгаа хийх, саналын төсөл боловсруулах; - Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсгийн хуралдаанд хүргүүлэх; - Засгийн газар болон Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсгээс өгсөн удирдамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; - Жилдээ. 	<p>Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын Комиссын хуралдаанд танилцуулсан байна.</p>	<p>ТӨБХХ</p>	<p>Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн маргаантай асуудлаарх Ерөнхий сайдын 2016 оны 91 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хуралдааныг 3 удаа зохион байгуулсан.</p> <p>Засгийн газар хоорондын хэлэлцээр, протоколд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлаар нийт 15 албан бичгийг холбогдох байгууллагад хүргүүлж, ноот бичгийн төслийг Засгийн газрын хуралдаан, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд танилцуулан шийдвэрлүүлсэн.</p> <p>Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын комиссын хуралдаанд үл хөдлөх хөрөнгийн асуудлаар танилцуулга бэлтгэн хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн.</p> <p>Тайлант хугацаанд, мөн ОХУ-ын талын Ажлын хэсэгтэй уулзалт</p>

				зохион байгуулах, ОХУ-ын Монгол Улс дахь өмчийн асуудлаар албан бичгийн хариу өгөх, санал боловсруулж хүргүүлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн. (Хэрэгжих шатанд – 70%)
ХӨТӨЛБӨР II				
“Төрийн болон орон нутгийн өмчийн бодлого, удирдлагын оновчтой хэлбэрийг хэрэгжүүлж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх, төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд:				
<p>Арга хэмжээ 1.2.1 (9)</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрд ногдох ногдол ашгийг төвлөрүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ногдол ашгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангах, хяналт тавих; - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн аудитаар баталгаажсан 2018 оны санхүүгийн тайлангийн дүнд үндэслэн төрд ногдох ногдол ашгийн тооцоог хийх; - Ногдол ашгийн тооцоог Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулан батлуулах; - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд ногдол ашиг төвлөрүүлэх тухай албан бичиг хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлэх; 	<p>Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ногдол ашгийн орлого 9,930.0 сая төгрөгийг улсын төсөвт, Ирээдүйн өв санд 300,870.0 сая төгрөгийг тус тус төвлөрүүлнэ.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоолоор батлагдсан төрийн өмчийн ногдол ашгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлнэ.</p>	<p>БТУХ</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох тухай, Монгол Улсын Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчийн хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг тогтоох тухай асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулав.</p> <p>1.ТӨБЗГ-ын 2019 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 229 дүгээр тогтоолоор нийт 45 хуулийн этгээд 11.2 тэрбум төгрөгийн ногдол ашгийг 2019 онд улсын төсөвт төвлөрүүлэхээр шийдвэрлэж, холбогдох албан бичгийг хуулийн этгээдэд хүргүүлэв. Ийнхүү зохион байгуулалтын арга хэмжээ авч, хяналт тавин ажиллаж байна.</p> <p>2.Аудитаар баталгаажсан 2018 оны санхүүгийн тайлан тэнцлээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 52 хуулийн этгээд цэвэр ашигтай ажилласнаас нэр бүхий 5 хуулийн этгээд (“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ, “Эрдэнэс таван толгой” ХК, “Эрдэнэс Монгол” ХХК, “Багануур” ХК)-ээс Ирээдүйн өв санд орлого төвлөрүүлэх тухай асуудлыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулсан. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн орлогоос Ирээдүйн өв санд (Улсын төсөвт хамаарна) 300 тэрбум 870 сая төгрөгийг төвлөрүүлэхээр тусгагдсан боловч Засгийн газрын 2019 оны 16 дугаар тэмдэглэлээр “Эрдэнэс таван толгой” ХК-ийн ногдол ашиг хуваарилах талаар гаргасан уг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолыг хүчингүй болгосон тул Ирээдүйн өв санд төвлөрүүлэх 144.8 тэрбум төгрөгийн орлого тасрахаар болсныг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулсан.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар Улсын төсвийн Ирээдүйн өв санд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын төвлөрүүлэх төрийн өмчийн ногдол ашгийн хувь хэмжээг хэвээр үлдээж, “Эрдэнэс таван толгой” ХК-ийг</p>	

	<ul style="list-style-type: none"> - I-IV улиралд. 			<p>хасаж, “Эрдэнэс Монгол” ХХК болон “Багануур” ХК-аас саналыг нь авч албажуулахаар шийдвэрлэсэн. “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд 2019 онд Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээний саналаа ирүүлэх талаар албан бичгээр хандахад ногдол ашиг хуваарилах боломжгүй тухай хариу ирүүлсэн.</p> <p>Иймд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 231 дүгээр тогтоолоор Ирээдүйн өв санд төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг нийт 151,568,566,276.28 (Нэг зуун тавин нэгэн тэрбум таван зуун жаран найман сая таван зуун жаран зургаан мянга хоёр зуун далан зургаан төгрөг хорин найман мөнгө) төгрөг буюу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас 150,000,000,000.00 төгрөг, “Монголросцветмет” ТӨҮГ-аас 1,568,566,276.28 төгрөгийг тус тус төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p>3.2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар төрийн өмчийн ногдол ашгийн 162.4 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. (Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 1.2.2 (10)</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг газрын хуралдаанд танилцуулах, шийдвэрлүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах; - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулах, батлуулах; - I улиралд. 	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг газрын хуралдаанаар батлуулсан байна.</p>	<p>БТУХ</p>	<p>2019 оны 1 дүгээр сард, ТӨБЗГ-ын даргын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн хурлаар төрийн өмчит 36 компани, үйлдвэрийн газрын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэлэлцэн үнэлэлт, дүгнэлт өгч, ТӨБЗГ-ын хуралдаанаар шийдвэрлүүлсэн. Түүнчлэн, “Монгол-Кувейтын байгаль хамгаалах төв” ТӨҮГ, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Монголросцветмет” ТӨҮГ-ын 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж батлуулав.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>

<p>Арга хэмжээ 1.2.3 (11)</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг газрын хуралдаанд танилцуулах, шийдвэрлүүлэх.</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах; - Ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргах; - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулах, батлуулах; - IV улиралд. 	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг газрын хуралдаанаар батлуулсан байна.</p>	<p>БТУХ</p>	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2020 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хуваарийн дагуу 2019 оны 12 дугаар сард батална. (Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй – ХБ.)</p>
<p>Арга хэмжээ 1.2.4 (12)</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэн, гэрээг сунгах эсэх шийдвэрийг газрын хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэн, захирлын контрактыг сунгах эсэх асуудлыг ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэх; - Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанд танилцуулж, гэрээг сунгах эсэх шийдвэрийг гаргуулах 	<p>Захирал, гүйцэтгэх захиралтай байгуулсан контрактын биелэлтийг дүгнэж, сунгах эсэх асуудлыг Газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн байна.</p>	<p>БТУХ</p>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2019 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А/99 дүгээр тушаалаар байгуулагдсан төрийн өмчит компани, үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан контракт, 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийг хянан үзэж, санал дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн хурлаар нийт 44 хуулийн этгээдийн захиралтай байгуулсан контрактыг хэлэлцэж, дүгнэлтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн хуралдаанд танилцуулан шийдвэр гаргуулсан. Хуралдааны шийдвэрээр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 260 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу төрийн өмчит нийт 19 үйлдвэрийн газрын захиралтай контракт байгуулсан. Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд гүйцэтгэх захиралтай байгуулах контрактыг 1 жилээр байгуулах тухай удирдамж, чиглэл өгөв.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>

	ажлыг хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу зохион байгуулах; - II улиралд.			
Арга хэмжээ 1.2.5 (13) Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2018 оны жилийн эцсийн санхүү, эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн нэгтгэл болон хууль эрх зүйн товхимол, гарын авлага гаргаж, сурталчлах	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2011-2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг нэгтгэх; - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд үйлчилж буй хууль, эрх зүйн баримт бичгүүдийг нэгтгэн гаргах; - Товхимол, гарын авлага хэвлүүлсэн байх; - Холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн байх; - II, IV улиралд. 	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн мэдээлэл болон хууль эрх зүйн товхимол, гарын авлага бүхий нэгдсэн мэдээлэлтэй болно.	БТУХ	<p>Төрийн өмчит болон төрийн оролцоотой хуулийн этгээдийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн дүн, 2011-2018 оны үр ашгийн үзүүлэлт, улсын төсөвт төвлөрүүлсэн татвар хураамжийн орлого, компани бүрийн танилцуулга мэдээлэл зэргийг нэгтгэсэн товхимлыг шинэчлэн бэлтгэв. Уг товхимлыг 35 ширхэг хэвлүүлэн холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.</p> <p>Товхимолд агуулсан нэгтгэлд ТӨБЗГ-ын төлөөлөл хэрэгжүүлдэг төрийн өмчит 21 үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой 4 компани, төрийн өмчит 44 компани, хязгаарлагдмал хариуцлагатай 8 компани, Сангийн яамны төлөөлөл хэрэгжүүлдэг 4 компани, "Эрдэнэс Монгол" ХХК-ийн төлөөлөл хэрэгжүүлдэг 11 компанийн санхүү, эдийн засгийн мэдээллийг тусгасан болно (Хөгжлийн банк, Төрийн банкны дүн ороогүй). Төрийн өмчит болон төрийн оролцоотой хуулийн этгээд нь 2018 оны жилийн эцсийн байдлаар 32 их наяд 48 тэрбум төгрөгийн хөрөнгө эзэмшиж, 46.1 мянга гаруй ажиллагсадтайгаар үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>(Хэрэгжих шатанд – 70%)</p>
Арга хэмжээ 1.2.6 (14) Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн менежментийг сайжруулах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн "Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага-2019" нээлттэй өдөрлөг зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага -2019" нээлттэй өдөрлөг зохион байгуулах үүрэг бүхий ерөнхий болон дэд ажлын хэсгийг байгуулах; - Холбогдох байгууллагаас зөвшөөрөл авах; - Нээлттэй өдөрлөг зохион байгуулахад шаардлагатай санхүүжилтийн тооцоо, төсвийн төсөл бэлтгэх; 	"Төрийн өмчийн менежмент, нийгмийн хариуцлага – 2019" нээлттэй өдөрлөг зохион байгуулж, тайланг даргын Зөвлөлөөр хэлэлцүүлэн үнэлэлт, дүгнэлт өгсөн байна. Төрийн өмчит болон төрийн	БТУХ	Хэрэгжээгүй – 0.

	<ul style="list-style-type: none"> - Хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлэх; - Өдөрлөгт оролцох төрийн өмчит хуулийн этгээдийг удирдлага, зохион байгуулалтаар хангах; - II улиралд. 	<p>өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан байна.</p>		
<p>Арга хэмжээ 1.2.7 (15)</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, үйл ажиллагааны мэдээлэл, эдийн засгийн үзүүлэлтийн ил тод байдлыг хангах арга хэмжээ авч, хяналт тавих</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг чиглэл, зөвлөмжөөр хангах; - Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийж, хяналт тавих; - Дотоод аудитын дүнг нэгтгэж, дүнгийн мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - Дотоод аудит, хяналтын мэдээллийг цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлэх; - Жилдээ. 	<p>Шилэн дансны тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилт хангагдана.</p>	ЗХЗХ	<p>2019 оны 1 дүгээр сард төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 75 хуулийн этгээдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд (2018 оны жилийн эцсийн байдлаар) дотоод аудит хийж гүйцэтгэсэн. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт дунджаар 95.0 хувь буюу "Сайжруулалт хэрэгтэй" гэсэн үнэлгээтэй дүгнэгдэв. Аудитын дүн, дүгнэлтийг үндэслэн аудитад хамрагдсан төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд 3 зөвлөмж өгч, "Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай" 2019 оны А-1/298-313 дугаартай албан бичгийг 16 хуулийн этгээдэд хүргүүлсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээ тайлангаа хуульд заасан хугацаанд бүрэн оруулах, 2. Байгууллагын өөрийн цахим хуудас дахь шилэн дансны цэсээ тогтмол шинэчлэн мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, 3. Байгууллагын удирдлага болон дотоод аудитын алба, нэгжийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах. <p>(Бүрэн хэрэгжсэн -100%)</p>
<p>Арга хэмжээ 1.2.8 (16)</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ажилтнуудад хууль эрх зүйн сургалт зохион байгуулан,</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэлээр 	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн албан хаагчдын хууль</p>	ЗХЗХ, БТУХ	<p>Тайлант хугацаанд, "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК-ийн төв, орон нутгийн удирдах ажилтны семинар, Эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн худалдан авах ажиллагааны ажилтнууд, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын удирдлага, худалдан авах ажиллагааг зохион байгуулахад оролцдог албан хаагчдад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангахад анхаарах асуудал, хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн тухай танилцуулга, худалдан авах</p>

чадавхжуулах	<p>сургалт зохион байгуулах;</p> <p>- Сургалтын үр дүнг тайлагнах;</p> <p>- Жилдээ.</p>	эрх зүйн мэдлэг ойлголт сайжирсан байна.		<p>ажиллагааны талаарх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, худалдан авах ажиллагааны цахим системийг ашиглах чадавхийг сайжруулахад чиглэсэн сургалт семинарыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулсан.</p> <p>Авлигын эсрэг хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Авлигын эсрэг сургалт, соён гэгээрүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөө”-ний төсөл боловсруулж, саналыг А-1/794 дугаартай албан бичгээр АТГ-т хүргүүлэн зөвшилцөж, хамтарсан төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байна. 2019 онд нийт 13 төрлийн сургалт, арга хэмжээ зохион байгуулж, ТӨБЗГ, түүний харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн давхардсан тоогоор 1301 албан хаагчийг хамруулахаар төлөвлөв. Эхний хагас жилд давхардсан тоогоор төрийн өмчит 70 хуулийн этгээд, байгууллагын нийт 781 албан хаагчийг авлигын эсрэг сургалтад хамруулсан байна.</p> <p>(Хэрэгжих шатанд - 70%)</p>
<p>Хоёр. “Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалт, хамгаалалттай холбоотой бүртгэл, тооллого явуулах, төрийн өмчийн бүрэн бүтэн байдал, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн байдалд хяналт тавих” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</p>				
<p>ХӨТӨЛБӨР III</p> <p>“Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгөд бүртгэлээр тавих хяналтыг боловсронгуй болгож, өмчийн улсын бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлэн баяжуулж, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хөдөлгөөнийг зохицуулах” хөтөлбөрийн хүрээнд:</p>				
<p>Арга хэмжээ 2.3.1 (17)</p> <p>Нийслэл, 21 аймгийн Орон нутгийн өмчийн нэгжээс орон нутгийн өмчит хуулийн этгээдийн газар эзэмших ашиглах эрхийг үнэлэх, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний үр дүнг хүлээн авах, нэгтгэх</p>	<p>- Нийслэлийн өмчийн харилцааны газар, 21 аймгийн Орон нутгийн өмчийн газартай хамтран ажиллаж, орон нутгийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 4621 хуулийн этгээдийн үнэлгээний дүнг нягтлан хүлээн авах;</p> <p>- Улсын нэгдсэн дүнг гаргаж, дүгнэлт, танилцуулга бэлтгэх;</p> <p>- II улиралд.</p>	Орон нутгийн өмчийн дахин үнэлгээний дүнг хүлээн авч нэгтгэсэн байна. Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний улсын нэгдсэн дүн гарч, танилцуулагдсан байна.	ТӨБХХ	Орон нутгийн өмчийн нэгжээс үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний дүнг аймаг, нийслэлийн ИТХ-аар хэлэлцүүлсэн тайлан, мэдээг хүлээн авч, нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчит 4243 хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлэх, үл хөдлөх хөрөнгийг дахин үнэлэх ажлын үр дүнг 8 төрлийн хүснэгтээр нэгтгэн боловсруулсан. Үнэлгээний нэгтгэлийг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэв. (Хэрэгжих шатанд – 70%)
<p>Арга хэмжээ 2.3.2 (18)</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн</p>	<p>- Төрийн болон орон нутгийн өмчийн 4621 хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн дахин</p>	Улсын нэгдсэн дүнг гаргасан байна.	ТӨБХХ	Төрийн болон орон нутгийн өмчийн 5293 хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрхийг үнэлэх, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, шийдвэрийн төслийг боловсруулж, ТӨБЗГ-ын хуралдаанаар

<p>этгээдийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний үр дүнг нэгтгэн боловсруулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, шийдвэрийн төсөл бэлтгэх, тайлагнах</p>	<p>үнэлгээний дүнгийн нэгтгэлийг нягтлах;</p> <ul style="list-style-type: none"> - Орон нутгийн өмчийн дүнтэй нэгтгэн улсын нэгдсэн дүнг гаргах, санал, дүгнэлт боловсруулах; - Шийдвэрийн төсөл бэлтгэж, ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулах; - Засгийн газарт хүргүүлэн тайлагнах; - VI сард. 	<p>ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулж, Засгийн газарт тайлагнасан байна.</p>		<p>хэлэлцүүлэхээр бэлтгэв. (Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 2.3.3 (19)</p> <p>Төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины тоо, төрлийг шинэчлэн тогтоох асуудлыг Газрын хуралдаанд танилцуулах, холбогдох шийдвэр гаргуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчит нийт 610 хуулийн этгээдийн автомашины судалгааг шинэчлэн гаргаж, нэгтгэх; - Засгийн газарт танилцуулах арга хэмжээ авах; - II улиралд. 	<p>Төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины судалгааг нэгтгэж, авах арга хэмжээг тодорхойлсон байна.</p>	<p>ТӨБХХ</p>	<p>Засгийн газрын 2015 оны 184 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор 2018 онд төрийн өмчит хуулийн этгээдийн автомашины судалгаа, зардлын судалгааг авч нэгтгэн дээд шатны байгууллагад саналаа боловсруулж хүргүүлсэн. Шийдвэр гараагүй.</p> <p>ЗГХЭГ-аас автомашины тоо төрөл болон зардлын судалгааг шинэчлэн тогтоох чиглэл өгсний дагуу 1200 гаруй хуулийн этгээдийн мэдээллийг хүлээн авч дүнг нэгтгэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Дээрх тогтоолын дагуу төрийн байгууллагуудын дотоод албан хэрэгцээнд ашиглах автомашины тоо, зардалд хяналт тавьж, хуучин автомашин худалдан авч засварын зардал гаргадаг, моторын багтаамж ихтэй автомашин олж авч шатахуун их зарцуулдаг асуудлыг багасгах зорилгоор шинээр худалдан авах автомашинд тодорхой шалгуур тавьж, зөвшөөрөл олгосноор зардал хэмнэх нөхцлийг бүрдүүлэх бодлого барьж ажилласан.</p> <p>Нэмэлт мэдээлэл: 2019 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн өмчит 20 хуулийн этгээдийн 1,159.0 сая төгрөгийн балансын үнэ бүхий 61 машиныг дуудлагын худалдаагаар худалдах тухай асуудлыг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, 20 тогтоол гарсан байна.</p> <p>2019 оны эхний хагас жилийн байдлаар 2018, 2019 оны дуудлагын худалдааны тогтоолын хэрэгжилтийн дүнд дуудлагын худалдааны орлогоос 170.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.</p>

				(Хэрэгжилт хангалтгүй – 30%)
<p>Арга хэмжээ 2.3.4 (20)</p> <p>Төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн өмчийн "Захиргааны статистикийн мэдээлэл"-ийг боловсруулж тайлагнах, дүн шинжилгээ хийх, танилцуулга, лавлагаа бэлтгэж тайлагнах</p>	<ul style="list-style-type: none"> - 2018 оны жилийн эцсийн мэдээ тайланг маягтын дагуу хянан, хүлээн авч нэгтгэх; - Төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн өмчийн захиргааны статистикийн мэдээллийг 2019 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн дотор цахимаар хүлээн авах; - Мэдээ тайланг нэгтгэх, тайлагнах, дүн шинжилгээ хийх, танилцуулга, лавлагаа бэлтгэх; - II улиралд. 	Мэдээ тайланг нэгтгэж, улсын нэгтгэлийг гаргасан байна.	ТӨБХХ	<p>Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн Захиргааны статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн хорооноос баталсан 8 төрлийн маягтын дагуу хүлээн авч, хянан, нэгтгэж, Үндэсний Статистикийн Хороонд 3 дугаар сарын 15-ны өдрийн А-5/712 дугаар албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p>Арга хэмжээ 2.3.5 (21)</p> <p>Аймаг, нийслэл, орон нутаг дахь төрийн өмчит хуулийн этгээдэд "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г дүгнэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэх</p>	<ul style="list-style-type: none"> - "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2018 оны биелэлтийг дүгнэх ажлыг зохион байгуулах удирдамж, төсвийн тооцоог хийх, 21 аймаг, нийслэлд ажиллах хуваарийг боловсруулах; - Газрын даргын тушаалын төслийг боловсруулах; - Удирдамжийн дагуу нийслэл, 21 аймаг дахь төрийн өмчит 1035 хуулийн этгээдэд "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-г дүгнэх; - Дүнг нэгтгэн газрын хуралдаанд танилцуулах; - II улиралд. 	<p>Нийт 1035 хуулийн этгээдийн 2018 оны өмч эзэмшлийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулсан байна.</p> <p>Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2018 оны биелэлтийн дүнг нэгтгэсэн байна.</p>	ТӨБХХ	<p>Төрийн өмчит хуулийн этгээдийн "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2017 оны биелэлтийн дүнгийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай ТӨБЗГ-ын 2018 оны 657 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор "Зөвлөмж" боловсруулан 2019 оны А-5/424 дүгээр албан бичгээр төрийн өмчит хуулийн этгээдэд хүргүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллав.</p> <p>"Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам"-ийг шинэчлэн боловсруулж, ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэсэн.</p> <p>Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын дагуу зохион байгуулагдсан төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний дүнг нэгтгэн тайлагнах ажилтай холбогдуулан "Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2018 оны биелэлтийг 2019 оны сүүлийн хагас жилд зохион байгуулахаар төлөвлөсөн болно.</p> <p>(Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй – ХБ.)</p>
<p>Арга хэмжээ 2.3.6 (22)</p>	<ul style="list-style-type: none"> - 2018 онд төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ 	2019 онд төрийн өөрийн	ТӨБХХ	2018 онд Төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээ байгуулаагүй улсын төсөвт орлого төвлөрүүлсэн төрийн өмчит 11 хуулийн

<p>Төрийн өмчит хуулийн этгээдийн түрээсийн гэрээг шинэчлэн байгуулах ажлыг зохион байгуулж, түрээсийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэх</p>	<p>байгуулаагүй боловч улсын төсөвт орлого төвлөрүүлсэн төрийн өмчит 11 хуулийн этгээдтэй түрээсийн гэрээг шинэчлэн байгуулах;</p> <ul style="list-style-type: none"> - Шинэчлэн байгуулсан түрээсийн гэрээний орлогын 30 хувийг улсын төсөвт төвлөрүүлэх; - Түрээсийн орлогын 600.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх; - Нийт 126 хуулийн этгээдийн түрээсийн гэрээг сунгах; - Жилдээ. 	<p>өмчийг түрээслүүлсний орлого 600.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.</p>	<p>этгээдэд 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А-5/97 дугаар албан бичгээр холбогдох хууль тогтоомж дагуу төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэхдээ сонгон шалгаруулалт зохион байгуулсны үндсэн дээр түрээслэгч этгээдтэй түрээсийн гэрээ байгуулан ажиллаж, түрээсийн нийт орлогын 30 хувийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу улсын төсөвт төвлөрүүлэх тухай албан бичгийг хүргүүлсэн. 11 хуулийн этгээдээс 6 нь гэрээ байгуулахаар материалаа ирүүлснээс 4 хуулийн этгээдийн гэрээг байгуулан хүргүүлсэн байна.</p> <p>Төрийн өмчит 45 хуулийн этгээдтэй 2018 онд байгуулсан төрийн өөрийн өмчийн түрээсийн гэрээг дүгнэж, хангалттай гэж дүгнэсэн тохиолдолд гэрээний сунгалт хийж, баталгаажуулах тухай 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А-5/96 дугаар албан бичгийг хүргүүлсэн. 45 хуулийн этгээдээс 35-тай нь гэрээний сунгалтыг хийсэн байна.</p> <p>2019 оны эхний хагас жилийн дүнгээр, 61 хуулийн этгээдийн 338 түрээсийн гэрээний сунгалт, шинээр 71 хуулийн этгээдийн 150 түрээсийн гэрээ, нийт 132 хуулийн этгээдийн 488 түрээсийн гэрээ болон сунгалтыг ТӨБЗГ-т хянан баталгаажуулсан.</p> <p>Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлсний орлогоос, 2019 оны эхний хагас жилийн байдлаар, улсын төсөвт 808.0 сая төгрөгийг хууль, журамд заасны дагуу төвлөрүүлсэн.</p> <p>(Хэрэгжих шатанд – 70%)</p>
---	--	--	--

ХӨТӨЛБӨР ҮҮ

“Төрийн өмчийн эзэмшилт, ашиглалтын үр өгөөжид мониторинг хийх, өмчийн болон санхүүгийн хяналт шалгалтын үр нөлөөг сайжруулах” хөтөлбөрийн хүрээнд:

<p>Арга хэмжээ 2.4.1 (23)</p> <p>Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд батлагдсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу баримтын шалгалт хийх</p>	<ul style="list-style-type: none"> - Хяналт шалгалтын төлөвлөгөөний төслийг боловсруулах; - Төлөвлөгөөний төслийг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулах, батлуулах; - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 29 хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үйл 	<p>Батлагдсан төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийгдэж, илэрсэн зөрчил доголдлыг арилгуулах арга хэмжээ авсан байна.</p>	<p>ТӨБХХ</p>	<p>2019 онд төрийн өмчийн оролцоотой 5 компани, төрийн өмчит 20 компани, төрийн өмчит 4 үйлдвэрийн газрын үндсэн болон санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийхээр төлөвлөгөө, хуваарийг ТӨБЗГ-ын 12 дугаар тогтоолоор баталсан.</p> <p>2019 оны эхний хагас жилийн байдлаар, нийт 16 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд баримтын шалгалт хийж, 9 байгууллагын тайланг ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулан, “Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолыг гаргуулан, албан бичгээр хүргүүлсэн. Үүнд:</p>
--	--	--	--------------	--

	<p>ажиллагаанд баримтын шалгалт хийх;</p> <ul style="list-style-type: none"> - Шалгалтын дүнг ТӨБЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлж, авах арга хэмжээний талаар шийдвэр гаргуулах; - Засгийн газрын 2018 оны 42 дугаар хуралдааны тэмдэглэлийг хэрэгжүүлэх; - Жилдээ. 	<p>Шалгалтын дүнг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлсэн байна.</p>	<ul style="list-style-type: none"> - “МИАТ” ТӨХК; - “Эрдэнэт Үйлдвэр” ХХК (хуучин нэрээр); - “Монголросцветмет” ХХК (хуучин нэрээр); - “Монгол шуудан” ХК; - “Чингис хаан олон Улсын нисэх буудал” ТӨҮГ; - “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ; - “Эрчим хүчний хөгжлийн төв” ТӨҮГ; - “Дарханы дулааны цахилгаан станц” ТӨХК; - “Дарханы дулааны сүлжээ” ТӨХК; - “Багануур” ХК; - “Шивээ овоо” ХК; - Иргэний нисэхийн ерөнхий газар; - “Дархан АЗЗА” ТӨХК; - “Төв АЗЗА” ТӨХК; - “Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨҮГ; - “Дорноговь АЗЗА” ТӨХК. <p>Нийт 16 байгууллага шалгалтад хамрагдсанаас “Монгол шуудан” ХК, “Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ, “Шивээ овоо” ХК-д хийсэн хяналт шалгалтын тайланг ТӨБЗГ-ын ээлжит хуралдаанд танилцуулахаар бэлтгэсэн.</p> <p>Эдгээр 16 хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 40.9 тэрбум төгрөгийн зөрчил, дутагдал илэрсэн байна. Зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авч, үр дүнг тайлагнан мэдээлэх талаар холбогдох хуулийн этгээдэд ТӨБЗГ-ын тогтоол, холбогдох албан бичгээр үүрэг, чиглэл өгсөн.</p> <p>Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 42 дугаар хуралдааны тэмдэглэлийн 2 дахь заалтын хэрэгжилтийг хангах үүднээс хяналт шалгалтын тайлан болон илэрсэн нийт зөрчлийн эрх зүйн үндэслэл, тэдгээрийг давтан гаргахгүй байх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай Эрчим хүчний сайд Ц.Даваасүрэнд А-1/806, Барилга, хот байгуулалтын яамны сайд Х.Баделханд А-1/1622, Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгд А-1/1623, Зам, тээврийн хөгжлийн сайд Б.Энхамгаланд А-2/1898, А-2/1899 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлсэн.</p> <p>Сангийн сайдын 2019 оны 54 дүгээр тушаалын дагуу “Эрдэнэт</p>
--	---	--	--

				<p>үйлдвэр” ХХК, “Монголросцветмет” ХХК-ийн 2016-2019 оны үйл ажиллагаанд санхүүгийн иж бүрэн шалгалт хийсэн хамтарсан ажлын хэсгийн гишүүдийн тайланг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогтод А-1/1254 дугаартай албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Төлөвлөгөөт бус шалгалтын хүрээнд “Нандин хул” ХХК-ийн гаргасан гомдлын дагуу “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын шинжээчийг ажлын хэсэгт ажиллуулж, дүгнэлт гарган шалгалтын тайлан бэлтгэв.</p> <p>(Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 2.4.2 (24)</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хөрөнгийн болон газар эзэмшилт, тэдгээрийн ашиглалт, хамгаалалт, худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэрэгжилтэд мониторинг хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчит 8 эмнэлэг, 1 сургуулийн хөрөнгө, газар эзэмшилт, тэдгээрийн ашиглалт, хамгаалалтад мониторинг хийж, үнэлэлт дүгнэлт өгөх; - ТӨБЗГ-ын хуралдаанд танилцуулж, шийдвэр гаргуулах; - Шийдвэрийн мөрөөр холбогдох арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжүүлэх; - Жилдээ. 	<p>Тайланг гаргаж, биелэлтийг хянах ажлыг зохион байгуулсан байна.</p> <p>Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт хангагдсан байна.</p>	<p>ТӨБХХ</p>	<p>Хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөны дагуу 8 их, дээд сургуулийн төрийн өмчийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт хамгаалалт, захиран зарцуулалт, газар эзэмшилт, ашиглалт, төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээс, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийн байдалд 2018 онд хийсэн мониторингийн дүнг ТӨБЗГ-ын 2019 оны хуралдаанд танилцуулан шийдвэрлүүлсэн.</p> <p>Шалгалтын дүн, тайлан, ТӨБЗГ-ын хуралдаанаас гарсан шийдвэр зэргийг холбогдох сайдад хүргүүлэв.</p> <p>Шалгалтад хамрагдсан их, дээд сургууль: МУИС, ШУТИС, АШУУИС, БИС, УИС, СУИС, ХААИС, ХҮИС.</p> <p>(Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй – ХБ.)</p>
<p>Гурав. “Худалдан авах ажиллагааг төлөвлөн батлагдсан төсвийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай байх зарчимд тулгуурлан зохион байгуулах, тайлагнах” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</p>				
<p>ХӨТӨЛБӨР Ү</p> <p>“Худалдан авах ажиллагааны хууль, эрх зүйн орчныг сайжруулж, олон улсын хөгжлийн чиг хандлагыг судлан, худалдан авах ажиллагааны чадавхийг бэхжүүлэн цахим худалдан авах ажиллагааг боловсронгуй болгох” хөтөлбөрийн хүрээнд:</p>				
<p>Арга хэмжээ 3.5.1 (25)</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт</p>	<ul style="list-style-type: none"> - Хуулийн төсөлд тусгах санал боловсруулах; - Хуулийн төсөлд тусгах саналыг холбогдох, байгууллага, оролцогчдоос авах ажлыг зохион байгуулах; - Саналыг Сангийн яаманд 	<p>Худалдан авах ажиллагааны хууль эрх зүйн орчин боловсронгуй болно.</p>	<p>Худалдан авах ажиллагааны хэлтэс (Цаашид “ХААХ” гэх), ЗХЗХ</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг Сангийн яаманд байгуулагдсан бөгөөд уг ажлын хэсэг ТӨБЗГ-ын төлөөлөл оролцсон болно.</p> <p>Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооноос эрхлэн 2 дугаар сарын 19-ний өдөр зохион байгуулсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах</p>

<p>оруулах тухай хуулийн төсөлд тусгах санал боловсруулах</p>	<p>хүргүүлэх; - Эхний хагас жилд.</p>			<p>тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хэлэлцүүлэгт ТӨБЗГ-ын удирдлага, Худалдан авах ажиллагааны хэлтэс, Мэдээлэл, технологийн албаны дарга, мэргэжилтнүүд оролцож, санал, мэдээлэл солилцов. Мөн 3 дугаар сарын 21-24-ний өдрүүдэд УИХ-ын ээлжит бус чуулганы нэгдсэн хуралдаан, Төсвийн байнгын хорооны хуралдаанаар тус тус хэлэлцүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэгт Газрын дарга Б.Ганбат, Мэдээлэл, технологийн албаны дарга Н.Цэрэнсамбуу нар оролцон мэдээлэл, танилцуулга хийв. УИХ-ын ээлжит бус чуулганы 3 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн шатны хэлэлцүүлэг хийгдэж, батлагдсан.</p> <p>04 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд Сангийн яамтай хамтран зохион байгуулсан Засгийн газрын 2018 оны худалдан авах ажиллагааны тайланг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт танилцуулах ажил хэргийн семинарын үеэр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, худалдан авах ажиллагааны цахим системийн хэрэглээ, цаашдын хөгжил, хандлагыг танилцуулав. (Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p>Арга хэмжээ 3.5.2 (26) Худалдан авах ажиллагаатай холбоотой журам, заавар, жишиг баримт бичгийг шинэчлэх төсөл боловсруулж, саналаа холбогдох байгууллагад хүргүүлэх</p>	<p>- Журам, зааврын төсөл боловсруулах; - Саналаа Сангийн яам, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх; - Жилдээ.</p>	<p>Худалдан авах ажиллагаатай холбоотой журам, заавар, жишиг баримт бичгийг шинэчилж, мөрдүүлсэн байна.</p>	<p>ХААХ, Мэдээлэл, технологийн алба (Цаашид “МТА” гэх)</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2019 оны 3 дугаар сард нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан “Тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”, “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-ын төслийг боловсруулах ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл ажиллаж, ажлын хэсгээс журмын төслийг боловсруулан, батлуулсан.</p> <p>Тайлант хугацаанд, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг танилцуулах, Гомдол хянан шийдвэрлэх журамд санал авах сургалт, семинарыг Сангийн яамтай хамтран зохион байгуулсан.</p> <p>Мөн “Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм”, “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл хөтлөх</p>

				<p>журам"-ын төслийг боловсруулах ажлын хэсэгт тус байгууллагын төлөөлөл томилогдон ажиллаж байгаа бөгөөд төсөлд олон нийтээс санал авахаар төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д нээлттэй байршуулаад байна.</p> <p>(Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 3.5.3 (27)</p> <p>2020 онд зохион байгуулах улсын болон бүс нутгийн чанартай төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, Ерөнхий гэрээгээр 2020 онд худалдан авах барааны жагсаалт батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Захиалагчаас санал авч нэгтгэх; - “Ерөнхий гэрээ”-ний худалдан авалтын жагсаалтад санал болгох бараа бүтээгдэхүүний эрэлт нийлүүлэлтийн судалгаа хийх; - Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгуулах; - Засгийн газрын шийдвэр, жагсаалтын төсөл боловсруулах; - Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах; - IV улиралд. 	<p>Хуулийн хугацаанд багтаан жагсаалтыг батлуулсан байна.</p>	<p>ХААХ</p>	<p>(Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй – ХБ.)</p>
<p>Арга хэмжээ 3.5.4 (28)</p> <p>2019 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг нэгтгэн боловсруулж, батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Батлагдсан жагсаалтад тусгагдсан төсөл, арга хэмжээ бүрийг тусгасан тухайн Төсвийн ерөнхийлөн захирагч нар, ТӨБЗГ-ын хамтарсан төлөвлөгөө батлах; - 2019 онд ТӨБЗГ-аас зохион байгуулах худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөг батлуулах; - Зохион байгуулах төсөл, арга хэмжээний ажлын даалгавар, зураг төслийг 	<p>Хуулийн хугацаанд багтаан хэрэгжүүлсэн байна.</p>	<p>ХААХ</p>	<p>Засгийн газрын 2018 оны 388 болон 2019 оны 46 дугаар тогтоолоор 2019 онд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт зохион байгуулах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны жагсаалт, аймаг, нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт, Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний жагсаалтыг тус тус баталсан. Засгийн газрын дээрх шийдвэрээр 369.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 169 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТӨБЗГ-т 2019 онд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.</p> <p>Төсөл, арга хэмжээ (т.а.х)-г захиалагч байгууллагаар нь авч үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> – Засгийн газрын Хэрэг эрхлэх газар - 1 т.а.х.; – Шадар сайдын ажлын алба - 1 т.а.х.; – Байгаль орчин, аялал жуулчлалын яам - 5 т.а.х.;

	<p>захиалагчаас хүлээн авч, худалдан авах ажиллагааны бэлтгэлийг хангах;</p> <ul style="list-style-type: none"> - I улиралд. 			<ul style="list-style-type: none"> - Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам - 1 т.а.х.; - Барилга, хот байгуулалтын яам - 6 т.а.х.; - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам - 102 т.а.х.; - Эрүүл мэндийн яам - 31 т.а.х.; - Зам, тээврийн хөгжлийн яам - 19 т.а.х.; - Эрчим хүчний яам - 3 т.а.х. <p>Засгийн газрын дээр дурдсан тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд захиалагч байгууллагуудтай худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хамтарсан тушаалаар батлан нийт 169 т.а.х.-ний нэгдсэн төлөвлөгөөг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn –д нээлттэй мэдээлэв. Уг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.</p> <p>2019 оны эхний хагас жилийн байдлаар нийт 169 т.а.х.-ээс 144 (85.2%) т.а.х.-ний зураг, төсөл, холбогдох материалыг захиалагчаас хүлээн авч, худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 1, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны 9, Барилга, хот байгуулалтын яамны 1, Зам, тээврийн хөгжлийн яамны 4, Эрүүл мэндийн яамны 10 т.а.х., нийт 25 т.а.х.-ний тендер шалгаруулалтад шаардлагатай зураг төсөл, холбогдох материалыг захиалагчаас ирүүлээгүй байгаагаас нийт төсөл, арга хэмжээний 14.8 хувийн худалдан авах ажиллагааг эхлүүлээгүй, хүлээгдэж байна. (Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 3.5.5 (29)</p> <p>Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон гадаадын бусад донор байгууллагуудтай хамтран ажиллах</p>	<ul style="list-style-type: none"> - Цаашид хамтран ажиллах тухай албан бичиг төлөвлөн, хүргүүлэх; - Дэлхийн банкны санхүүжилтээр “Ухаалаг засаг” төслийн хүрээнд хэрэгжих 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах; - Тухай бүр. 	Гадаадын хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл, арга хэмжээний худалдан авалт бүрэн хийгдэж, гэрээ байгуулсан байна.	ХААХ	<p>2019 онд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон гадаадын бусад донор байгууллагуудаас эрх шилжүүлж ирүүлсэн худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй байна.</p> <p>(Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй – ХБ.)</p>
<p>Арга хэмжээ 3.5.6 (30)</p> <p>Худалдан авах</p>	<ul style="list-style-type: none"> - Бэлтгэл хангуулах; - Дэлхийн банкны санхүүжилтээр Сангийн 	Орон нутагт худалдан авах ажиллагаа	ХААХ	<p>2019 оны эхний хагас жилийн байдлаар худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтын шалгалтыг 21 аймаг, Улаанбаатар хотод нийт 288 удаа цахим хэлбэрээр зохион</p>

<p>ажиллагааны суурь мэдлэг олгох сургалт зохион байгуулах</p>	<p>яам, ТББ-тай хамтран сургалт зохион байгуулах;</p> <ul style="list-style-type: none"> - Онлайн болон бусад хэлбэрээр шалгалт авч, гэрчилгээ (АЗ) олгох; - Жилдээ. 	<p>зохион байгуулах чадавх дээшилнэ. Сургалтад нийсэл, 21 аймгийн 7000 хүнийг хамруулсан байна.</p>		<p>байгуулж, 6640 суралцагчийг хамруулснаас 3746 (56.4%) суралцагч уг шалгалтад тэнцсэн бөгөөд тэдгээрт худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ (АЗ)-г олгосон байна. Шинээр гэрчилгээ авсан иргэн, албан хаагчдын мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn –д оруулж байна. Уг системд хүчин төгөлдөр гэрчилгээ бүхий нийт 16159 хүний мэдээлэл бүртгэлтэй байна.</p> <p>(Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 3.5.7 (31)</p> <p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, төрийн өмчит үйлдвэрийн газарт худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах арга хэмжээ авч, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, ТӨҮГ-уудыг албан хаагчдад хуваарилан хариуцуулах зохион байгуулалтыг хийх; - Зөвлөгөө, арга зүйгээр хангаж, сургалт, семинар зохион байгуулах; - Худалдан авах ажиллагаанд хяналт тавих; - Жилдээ. 	<p>Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, ТӨҮГ-уудын зохион байгуулж байгаа худалдан авах ажиллагаанд тавих хяналт сайжирна.</p>	<p>ХААХ, МТА</p>	<p>Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын дагуу ТӨБЗГ-ын төлөөлөл хэрэгжүүлдэг төрийн өмчит хуулийн этгээдийн худалдан авах ажиллагааны тайлан, төлөвлөгөөг хүлээн авч, 01 дүгээр сарын 15-ны байдлаар Сангийн яаманд хүргүүлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журамд заасан хугацааг мөрдөөгүй буюу хугацаа хоцорч ирүүлсэн төрийн өмчит хуулийн этгээдийн тайлан, төлөвлөгөөг нэгтгэх, төрийн худалдан авах ажиллагааны цахим системд буй өгөгдөлтэй тулган нягтлах ажлыг зохион байгуулсан. Энэ чиглэлээр арга зүйн удирдлагаар хангаж ажиллав.</p> <p>Цахим худалдан авах ажиллагааны системийн хэрэглэгчийн сургалтыг долоо хоног бүр зохион байгуулж, тендер шалгаруулалт зарлаж буй захиалагч 166 байгууллагын төлөөллийг хамруулж, чадавхижуулан мэргэжил, арга зүйн зөвлөгөө дэмжлэгээр хангав.</p> <p>2019 оны эхний хагас жилийн байдлаар, ТӨБЗГ-ын төлөөлөл хэрэгжүүлдэг төрийн өмчит хуулийн этгээдэд зохион байгуулах 2745 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн талаарх мэдээлэл төрийн худалдан авах ажиллагааны цахим систем https://www.tender.gov.mn -д нийтлэгдэж, 841 тендерийн урилга зарлагдсан. Үүнээс цахим тендер шалгаруулалтын 820 урилга байгаа нь нийт зарласан тендерийн 97.0% хувийг эзэлж байна. (Хэрэгжих шатанд – 70 %)</p>
<p>Арга хэмжээ 3.5.8 (32)</p> <p>Захиалагч болон тендерт оролцогчдод худалдан авах ажиллагааны хууль,</p>	<ul style="list-style-type: none"> - Орон нутгийн нэгжид мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх; - Зөвлөгөө, арга зүйгээр хангаж, сургалт, семинар 	<p>Орон нутгийн худалдан авах ажиллагааны нэгж, мэргэжилтнүү-</p>	<p>ХААХ</p>	<p>Захиалагч болон тендерт оролцогчдод худалдан авах ажиллагааны хууль, тогтоомжийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр өдөр тутамд хангаж ажиллав.</p> <p>(Хэрэгжих шатанд – 70 %)</p>

<p>тогтоомжийн талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх</p>	<p>зохион байгуулах; - Худалдан авах ажиллагаанд хяналт тавих; - Жилдээ.</p>	<p>дэд зөвлөгөө өгөх, шалган туслах ажлыг хийсэн байна.</p>		
<p>Арга хэмжээ 3.5.9 (33) Чанар, стандартын шаардлага хангасан барааг үйлдвэрлэдэг үндэсний үйлдвэрлэгчдийг тендер шалгаруулалтад хэрхэн оролцох талаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах</p>	<p>- Хуулийн давуу эрхийг хэрхэн ашиглаж тендер шалгаруулалтад оролцох талаар үндэсний үйлдвэрлэгч нарт зориулсан сургалт, уулзалт зохион байгуулах; - Худалдан авах ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулах; - Тендер шалгаруулалтын ил тод байдлыг хангаж ажиллах; - Жилдээ.</p>	<p>Үндэсний үйлдвэрийн худалдан авалт нэмэгдсэн байна.</p>	<p>ХААХ</p>	<p>Тайлант хугацаанд, захиалагчаас тухайн төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг, төсөл, ажлын даалгавар, холбогдох бусад материал ирүүлсэн 144 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг эхлүүлэн зохион байгуулж байна. Эдгээрийг худалдан авах ажиллагааны төрлөөр ангилж үзвэл:</p> <ul style="list-style-type: none"> - Ажил худалдан авах ажиллагаанд хамаарах 140 т.а.х.; - Бараа худалдан авах ажиллагаанд хамаарах 2 т.а.х.; - Үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хамаарах 2 т.а.х. байна. <p>Бараа худалдан авах ажиллагаанд хамаарах 2 т.а.х. нь Эрүүл мэндийн сайдын багцаас санхүүжигдэх эмнэлгийн тоног төхөөрөмж болон мотоцикл худалдан авах ажиллагаа юм. ТӨБЗГ-аас хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад дотоодод үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүн худалдан авах төсөл, арга хэмжээ тусгагдаагүй болно.</p> <p>Дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, дэмжих зорилгоор үндэсний үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэсэн, чанар, стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүнийг барилга угсралтын ажилд ашиглахаар бол бараа материал болон ажиллах хүчний хувьд дотоодын давуу эрх тооцохоор тендерийн баримт бичигт тусгасан. 2019 оны эхний хагас жилийн байдлаар, 144 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг ТӨБЗГ-т зохион байгуулж байгаа бөгөөд тендерийн нээлт хийгдсэн 63 төсөл, арга хэмжээнээс 20 төсөл, арга хэмжээнд оролцогч 39 компанид 6.2 тэрбум төгрөгийн дотоодын давуу эрхийн зөрүүг тооцоод байна.</p> <p>“Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээгээр худалдан авах” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах хүрээнд 32 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 17 аж ахуйн нэгжтэй 47 ерөнхий гэрээ байгуулсан бөгөөд 10 (31.3%) нэр төрлийн эмийн бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгчээс худалдан авч, эм, эмнэлгийн хэрэгслийн ханган нийлүүлэлтийг хийж, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжсэн байна.</p>

				<p>Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд ХХААХҮЯ-тай хамтран “Монголд үйлдвэрлэв” 2017, 2018 оны дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний каталогийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -ийн “Цахим дэлгүүр” хэсэгт байршуулж, худалдан авах ажиллагаанд оролцогч захиалагч, нийлүүлэгчдэд сурталчлан танилцуулав.</p> <p>(Хэрэгжих шатанд – 70 %)</p>
<p>Арга хэмжээ 3.5.10 (34)</p> <p>Үнэлгээний хорооны хурал зохион байгуулах нөхцлийг бүрдүүлэх, холбогдох тоног төхөөрөмжөөр хангах</p>	<ul style="list-style-type: none"> - Үнэлгээний хороо хуралдах орчинг бүрдүүлэх, холбогдох тоног төхөөрөмж худалдан авах; - Худалдан авах ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулах; - Тендер шалгаруулалтын ил тод байдлыг хангаж ажиллах; - Жилдээ. 	<p>Худалдан авах ажиллагаа хуулийн хугацаанд хууль, журам, зааврын дагуу зохион байгуулагдсан байна.</p>	<p>ХААХ</p>	<p>Үнэлгээний хорооны хурал зохион байгуулах хэвийн нөхцлийг хангаж ажилласан. Шаардлагатай тоног төхөөрөмжийг ашиглаж байгаа. Тайлант хугацаанд шинээр тоног төхөөрөмж худалдан аваагүй болно.</p> <p>(Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй – ХБ.)</p>
<p>Арга хэмжээ 3.5.11 (35)</p> <p>“Цахим дэлгүүр”, “Цахим каталог”-ийн системийг хэрэглээнд нэвтрүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Цахим дэлгүүрээр нийлүүлэх бараа, ажил, үйлчилгээний цахим каталогийн тоог нэмэх, ангиллыг сайжруулах; - Цахим дэлгүүрийн хэрэглээг өргөжүүлэх, захиалагч, нийлүүлэгчийн тоог нэмэх; - Захиалагч, нийлүүлэгч байгууллагуудыг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах; - Сар бүр. 	<p>Нийлүүлэгч, захиалагч байгууллагууд бараа, үйлчилгээгээ цахим дэлгүүрт бүртгүүлж, борлуулалт хийсэн байна. Төсвийн хэмнэлт, үр ашиг бий болсон байна.</p>	<p>МТА</p>	<p>“Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээгээр худалдан авах” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 32 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 17 нийлүүлэгч аж ахуйн нэгжтэй 47 ерөнхий гэрээ байгуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -ийн дэд систем болох “Цахим дэлгүүр”-ээр ерөнхий гэрээний худалдан авалтыг амжилттай гүйцэтгэж байна. 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар, ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааны үр дүнд “Цахим дэлгүүр”-ээр нийт 712 удаагийн захиалга хийгдэн 32 нэр төрлийн 3.9 тэрбум төгрөгийн эм, хэрэгсэл худалдан борлуулагдаж, улсын төсөвт 165.2 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.</p> <p>Эдгээрээс Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын “Элэгний В, С вирусийн илрүүлэг, шинжилгээнд шаардагдах түргэвчилсэн оношлуурыг худалдан авах ерөнхий гэрээ байгуулах” төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулсны дүнд шалгарсан 3 аж ахуйн нэгжтэй 2019 оны 03 сарын 22-ны өдөр ерөнхий гэрээ байгуулж, 2 дахь шатны сонгон</p>

				<p>шалгаруулалтыг “Цахим дэлгүүр”-ийн дэд системээр гүйцэтгэж байна.</p> <p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn –ний бараа, ажил, үйлчилгээний ангиллын системд нийт 26659 бараа, ажил, үйлчилгээ бүртгэлтэй байгаа нь өмнөх жилийн мөн үеэс 3850-иар (22809 байсан) нэмэгдсэн байна.</p> <p>Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих ажлын хүрээнд ХХААХҮЯ-тай хамтран “Монголд үйлдвэрлэв” 2017, 2018 оны дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүний каталогийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -ийн “Цахим дэлгүүр” хэсэгт байршуулж, худалдан авах ажиллагаанд оролцогч захиалагч, нийлүүлэгчдэд сурталчлан танилцуулав. (Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 3.5.12 (36)</p> <p>Захиалагч байгууллагууд, орон нутгийн нэгжүүд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудын цахим хэлбэрээр зохион байгуулах худалдан авах ажиллагааг арга зүйн удирдлага, зөвлөмж, мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Худалдан авах ажиллагааны салбарын албан хаагчид, төрийн байгууллага, захиалагч талын төлөөллийг оролцуулан цахим болон танхимын сургалт зохион байгуулах; - Цахим системийн ерөнхий заавар, аргачлал, гарын авлага бүхий мэдээллийг бэлтгэх, түгээх; - Жилдээ. 	<p>Цахим худалдан авах ажиллагааны талаарх олон нийтийн ойлголт, мэдлэг нэмэгдэж, системийн ашиглалт сайжирсан байна.</p>	<p>МТА</p>	<p>Тайлант оны 04 дүгээр сарын 24-26-ны өдрүүдэд Сангийн яамтай хамтран зохион байгуулсан Засгийн газрын 2018 оны худалдан авах ажиллагааны тайланг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт танилцуулах ажил хэргийн семинарын үеэр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт, худалдан авах ажиллагааны цахим системийн хэрэглээ, цаашдын хөгжил, хандлагыг танилцуулав.</p> <p>Түүнчлэн, Эрчим хүчний яам, Зам тээврийн яам, Барилга хот байгуулалтын яам, Мэдээлэл, технологи харилцаа холбооны газар, Байгаль орчны яам, Хөдөө аж ахуйн яамны хүсэлтийн дагуу хуулийн нэмэлт өөрчлөлт, шинэчлэлт, цахим системийн сургалтыг зохион байгуулсан.</p> <p>Цахим худалдан авах ажиллагааны системийн хэрэглэгчийн сургалтыг долоо хоног бүрийн Мягмар гарагт зохион байгуулж байна. Тайлант хугацаанд тендер шалгаруулалт зарлаж буй захиалагч 166 байгууллагын төлөөлөл хамрагдсан байна.</p> <p>“Тогтвортой амьжиргаа-3” төслөөс зохион байгуулсан Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтын шалгалтыг дараах нэр дурдсан аймгуудад цахим системээр авсан. Үүнд: Дархан-Уул аймаг, Завхан аймаг, Баян-Өлгий аймаг, Увс аймаг, Төв аймаг, Сүхбаатар аймаг, Дорнод аймаг, Хэнтий аймаг, Хөвсгөл аймаг.</p> <p>Авлигатай тэмцэх газрын олон нийтийн дэд зөвлөлийн орон нутгийн төлөөлөлд худалдан авах ажиллагааны ил тод байдал, цахим</p>

				худалдан авах ажиллагааны чиглэлээр, МУБИС-ийн холбогдох албан хаагчдад худалдан авах ажиллагааны цахим системийг ашиглах талаар семинар хийж, мэдээлэл өгсөн. (Бүрэн хэрэгжсэн – 100%)
Арга хэмжээ 3.5.13 (37) Худалдан авах ажиллагаанд оролцогч ААН-тэй хамтарсан сургалт, семинар, зохион байгуулах	- Худалдан авах ажиллагааны цахим системийн сургалт зохион байгуулах, ерөнхий заавар, аргачлал, гарын авлага бүхий мэдээллийг бэлтгэх, түгээх; - Жилдээ.	Худалдан авах ажиллагаанд оролцогч ААН-ийн чадавх нэмэгдсэн байна.	МТА	Цахим худалдан авах ажиллагааны системийн хэрэглэгчийн сургалтыг долоо хоног бүрийн Мягмар гараг зохион байгуулж байна. Тайлант хугацаанд, гүйцэтгэгч, нийлүүлэгч буюу тендерт оролцогч ААН, байгууллагын 290 төлөөлөл хамрагдсан байна. (Хэрэгжих шатанд – 70%)
Арга хэмжээ 3.5.14 (38) Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдлага, ажилтнуудад худалдан авах ажиллагааны талаар нэгдсэн сургалт, семинар зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр хангах	- Сургалт, семинарын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, батлуулах; - Зохион байгуулах; - Тайлагнах; - Жилдээ.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилт сайжирч, зөрчил дутагдал багассан байна.	ЗХЗХ, ТӨБХХ, ХААХ, БТУХ, МТА	“Мэдээлэл холбооны сүлжээ” ХХК-ийн төв, орон нутгийн удирдах ажилтны семинар, Эрчим хүчний салбарын төрийн өмчит компанийн худалдан авах ажиллагааны ажилтнууд, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын удирдлага, худалдан авах ажиллагааг зохион байгуулахад оролцдог албан хаагчдад Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг хангахад анхаарах асуудал, хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн тухай танилцуулга, мэдээлэл хийх, худалдан авах ажиллагааны цахим системийг ашиглах чадавхийг сайжруулахад чиглэсэн сургалт семинарыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулсан. Монгол Улсын Боловсролын Их сургууль болон түүний бүрэлдэхүүн, салбар сургуулийн санхүүгийн ажилтнуудад өмчийн хөдлөл өөрчлөлт болон өмчийн харилцааны бусад асуудлаар 2019 оны 05 дугаар сард сургалт зохион байгуулсан. Мөн ОБЕГ-ын харьяа байгууллагуудын 40 гаруй албан хаагчдад төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн сургалтыг зохион байгуулав. 2019 оны эхний хагас жилийн хугацаанд төрийн өмчит 16 хуулийн этгээдийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх, томилолтоор ажиллах хугацаандаа худалдан авах ажиллагааны талаар холбогдох мэргэжилтэн, албан хаагчдад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. (Хэрэгжилт хангалтгүй - 30%)
Арга хэмжээ 3.5.15 (39) Орон нутгийн нэгжийн	- Сургалт, семинарын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан, батлуулах,	Орон нутгийн нэгжийн албан хаагчдын	ЗХЗХ, ТӨБХХ, ХААХ,	Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 21 аймгийн орон нутаг дахь үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний нэгтгэлийг хянан хүлээн авах ажлыг зохион

<p>мэргэжилтнүүдэд сургалт, семинар зохион байгуулж, мэргэжил, арга зүйгээр хангах</p>	<p>зохион байгуулах, тайлагнах;</p> <ul style="list-style-type: none"> - 21 аймгийн Орон нутгийн өмчийн газар, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газар, Худалдан авах ажиллагааны газар, 9 дүүргийн худалдан авах ажиллагааны албаны хаагчдыг хамруулах; - Хууль тогтоомжийн өөрчлөлт, эрх бүхий байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, чиглэл зааврыг хүргүүлэн хэрэгжилтийг хангуулах; - Жилдээ. 	<p>хууль, эрх зүйн мэдлэг сайжирсан байна.</p>	<p>БТУХ, МТА</p>	<p>байгуулж, нэгдсэн цугларалт, сургалтыг Газрын даргын 2019 оны А/110 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу 2019 оны 4 дүгээр сарын 22-28-ны өдрүүдэд зохион байгуулсан.</p> <p>21 аймгийн Орон нутгийн өмчийн газар, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын нийт 80 гаруй мэргэжилтэнд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, ТӨБЗГ-ын бүртгэлийн мэргэжилтнүүд хуваарийн дагуу аймгийн төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээтэй холбоотой мэдээ, тайланг хүлээн авсан.</p> <p>ТӨБЗГ-ын даргын А/110 дугаар тушаалаар батлагдсан сургалтын хөтөлбөрийн дагуу 04 дүгээр сарын 24-ний өдөр нийслэл, 21 аймгийн орон нутгийн өмчийн нэгжийн удирдлага, мэргэжилтнүүдэд зориулсан сургалт семинар зохион байгуулав. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> – “Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, орон нутгийн өмчийг зохицуулах журам, Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаанд анхаарах асуудал” сэдвээр ТӨБХХ-ийн ахлах мэргэжилтэн Д.Нарангэрэл; – “Төрийн өмчийн бодлого, төлөвлөлт, төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх асуудал” сэдвээр БТУХ-ийн дарга Ц.Баяр-Эрдэнэ; – “Орон нутгийн өмч хувьчлалын зөвшилцөл, арга хэлбэр, анхаарах асуудал” сэдвээр БТУХ-ийн мэргэжилтэн Д.Эрэвгийлхам; – “Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих хяналт, шалгалтын асуудал” сэдвээр ТӨБХХ-ийн Д.Сувдмаа; – “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нь” сэдвээр АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн мэргэжилтэн, комиссар Ж.Сарангэрэл нар тус тус семинар өгөв. <p>Тайлант хугацаанд, Ус, цаг уур, орчны шинжилгээний газар болон түүний орон нутаг дахь салбар, харьяа байгууллага (21 аймаг, хүрээлэн)-ын албан хаагчдад эд хөрөнгийн зохицуулалт болон түрээсийн гэрээний талаар арга зүйн сургалт зохион байгуулсан.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
--	---	--	------------------	---

ХӨТӨЛБӨР ҮІ

“Худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулж, мэдээллийн санг бүрдүүлэн баяжуулах” хөтөлбөрийн хүрээнд:

<p>Арга хэмжээ 3.6.1 (40)</p> <p>Засгийн газрын 2018 оны 388 дугаар тогтоолын 1, 3 дугаар хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээ болон захиалагчаас эрх шилжиж ирсэн ажлуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Үнэлгээний хороо байгуулах; - Худалдан авах ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулах; - Шаардлагад нийцсэн тендерт оролцогчтой хуулийн хугацаанд гэрээ байгуулах; - Тендер шалгаруулалтын ил тод байдлыг хангаж ажиллах; - Жилдээ. 	<p>Худалдан авах ажиллагаа хуулийн хугацаанд хууль, журам, зааврын дагуу зохион байгуулагдсан байна.</p>	<p>ХААХ</p>	<p>Тайлант хугацаанд, ТӨБЗГ-аас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт 369.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 169 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулахаас тендер шалгаруулалтыг зохион байгуулахад шаардагдах техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон холбогдох материалыг захиалагчаас ирүүлсэн 144 (85.2%) төсөл, арга хэмжээ (т.а.х)-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий үнэлгээний хороог байгуулан ажиллуулав. Эдгээр үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тендер шалгаруулалтыг зохион байгуулж байна.</p> <p>Нийт 169 (100.0%) т.а.х-ний худалдан авах ажиллагааны явцын дүн:</p> <ul style="list-style-type: none"> – Гэрээ байгуулсан (албажиж байгаа) – 42 (24.9%) т.а.х; – Тендер нээсэн, үнэлгээ хийж байгаа – 46 (27.2%) т.а.х; – Тендер зарласан – 43 (25.4%) т.а.х; – Тендерийн баримт бичиг боловсруулж байгаа – 13 (7.7%) т.а.х; – Захиалагчаас зураг төсөл ирүүлээгүй байгаа – 25 (14.8%) т.а.х. <p>2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дүнгээр 80.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 42 т.а.х-ний худалдан авах ажиллагааг бүрэн зохион байгуулсны үр дүнд тендерт шалгарсан гүйцэтгэгчтэй нийт дүнгээр 70.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ байгуулагдаж, 10.1 тэрбум төгрөгийн улсын төсвийн хэмнэлт гаргасан байна.</p> <p>Худалдан авах ажиллагааны үр дүнг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn –д нийтэлж, олон нийтэд мэдээлэв.</p> <p>(Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 3.6.2 (41)</p> <p>2019 онд Ерөнхий гэрээгээр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Холбогдох яамнаас тухайн нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний судалгааг авах; - Ерөнхий гэрээгээр худалдан авах барааны тендерийн баримт бичгийг боловсруулан худалдан авалтыг цахим 	<p>2019 онд ерөнхий гэрээгээр худалдан авах барааг “Цахим дэлгүүр”-ээс худалдан авсан байна.</p>	<p>ХААХ, МТА</p>	<p>Засгийн газрын 2018 оны 388 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 2019 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны жагсаалт”-д тусгагдсан “Зарим ерөнхий нэршлийн эмийг ерөнхий гэрээгээр худалдан авах” төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 32 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 17 нийлүүлэгч аж ахуйн нэгжтэй 47 ерөнхий гэрээ байгуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -ийн дэд систем</p>

	<p>хэлбэрээр зохион байгуулах;</p> <ul style="list-style-type: none"> - Жилдээ. 			<p>болох “Цахим дэлгүүр”-ээр ерөнхий гэрээний худалдан авалтыг амжилттай гүйцэтгэж байна.</p> <p>2019 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар, ерөнхий гэрээний худалдан авах ажиллагааны үр дүнд “Цахим дэлгүүр”-ээр нийт 712 удаагийн захиалга хийгдэн 32 нэр төрлийн 3.9 тэрбум төгрөгийн эм, хэрэгсэл худалдан борлуулагдаж, улсын төсөвт 165.2 сая төгрөгийн хэмнэлт гарсан байна.</p> <p>Эдгээрээс Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын “Элэгний В, С вирусийн илрүүлэг, шинжилгээнд шаардагдах түргэвчилсэн оношлуурыг худалдан авах ерөнхий гэрээ байгуулах” төсөл, арга хэмжээний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг амжилттай зохион байгуулсны дүнд 2019 оны 03 сарын 22-ны өдөр шалгарсан 3 аж ахуйн нэгжтэй ерөнхий гэрээ байгуулж, 2 дахь шатны сонгон шалгаруулалтыг “Цахим дэлгүүр”-ийн дэд системээр гүйцэтгэж байна.</p> <p>Ерөнхий гэрээний энэхүү худалдан авалтын хүрээнд 10 (31.3%) нэр төрлийн эмийн бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгчээс худалдан авч, эм, эмнэлгийн хэрэгслийн ханган нийлүүлэлтийг хийж, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжсэн байна.</p> <p>(Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 3.6.3 (42)</p> <p>2019 онд зохион байгуулах тендерийн урилга, зарыг нийтлүүлэх өдөр тутмын сонинг сонгон шалгаруулах</p>	<ul style="list-style-type: none"> - Ажлын хэсэг байгуулах; - Нээлттэй сонгон шалгаруулалт зохион байгуулж, ил тод мэдээлэх, I сард; - Зохион байгуулагдаж буй төсөл, арга хэмжээний урилга, зарыг хуулийн хугацаанд шуурхай мэдээлэх; - Урилга нийтлүүлсэн өдөр тутмын сонин хэвлэлээр хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгөх; - Жилдээ. 	<p>Тендерийн урилга, зар, мэдээлэл олон нийтэд хүртээмжтэй, ил тод мэдээлэгдэнэ.</p>	<p>ХААХ</p>	<p>ТӨБЗГ-ын даргын 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/279 дугаартай тушаалаар ТӨБЗГ-аас 2019 онд зохион байгуулах худалдан авах ажиллагааны тендерийн урилга, зөвлөх үйлчилгээний зарыг олон нийтэд мэдээлэх өдөр тутмын сонинг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог байгуулан ажиллуулсан. Уг үнэлгээний хороо тендерийн баримт бичгийг боловсруулж, “Монгол шуудан” ХК-ийн хэвлэл захиалгын жагсаалтад орсон өдөр тутмын 8 сонинд саналын урилгыг хүргүүлсэн бөгөөд 5 сонин тендерт оролцсон. Үнэлгээний дүнгээр Засгийн газрын мэдээ, Өнөөдөр, Зууны мэдээ сонин шалгарсан. Өдөр тутмын эдгээр сонин редакцтай гэрээ байгуулж, хамтран ажиллаж байна.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>

<p>Арга хэмжээ 3.6.4 (43)</p> <p>2019 онд зохион байгуулах тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд ажиллах Төрийн бус байгууллага болон мэргэжлийн холбоодын шинэчилсэн бүртгэл хийх</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын шинэчилсэн бүртгэл хийх зарыг байгууллагын цахим хуудас болон сониноор зарлах; - Үнэлгээний хороонд ажиллах төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодыг зохих журмын дагуу сонгон шалгаруулах; - Шинээр бүртгэгдсэн ТББ-ын төлөөлөлтэй хамтран ажиллах гэрээ байгуулах; - I сард. 	<p>Тендер шалгаруулалтын үнэлгээний хороонд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэгч олон нийтийн төлөөллийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр ажиллуулж, хяналт хийлгэсэн байна.</p>	<p>ХААХ</p>	<p>ТӨБЗГ-аас 2019 онд зохион байгуулах улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахад оролцох төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран ажиллах нээлттэй урилгыг тус байгууллагын цахим хуудас www.pcsp.gov.mn болон өдөр тутмын сонинд нийтэлж, 2018 оны 12 дугаар сараас 2019 оны 2 дугаар сар хүртэл 3 сарын хугацаанд бүртгэлийг зохион байгуулсан. Шаардлага хангасан 32 төрийн бус байгууллагын 69 төлөөлөлтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж, худалдан авах ажиллагаанд олон нийтийн оролцоотой хяналтыг хэрэгжүүлж байна.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p>Арга хэмжээ 3.6.5 (44)</p> <p>Тендер шалгаруулалтын үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Гэрээ байгуулсан ажлын үр дүнг тухай бүр цахим хуудсанд нийтлэх; - Гэрээ байгуулсан ААН-ийн бүртгэлийг байгууллагын цахим хуудсанд ил тод байршуулах; - Худалдан авах ажиллагааны явц, үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх; - Жилдээ. 	<p>Худалдан авах ажиллагааны нээлттэй байдал хангагдсан байна.</p>	<p>ХААХ</p>	<p>ТӨБЗГ-т зохион байгуулагдаж байгаа худалдан авах ажиллагааг 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулж, тендер шалгаруулалтын үр дүн, явцын мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn –д болон байгууллагын цахим хуудас www.pcsp.gov.mn –нд тус тус нийтэлж, олон нийтэд нээлттэй мэдээлж байна. (Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 3.6.6 (45)</p> <p>2018 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны тайланг нэгтгэн боловсруулах</p>	<ul style="list-style-type: none"> - Зохион байгуулсан худалдан авах ажиллагааны нэгдсэн тайланг нэгтгэх; - Дүгнэлт, дүн шинжилгээ бүхий тайланг боловсруулах; - Тайланг Сангийн яаманд хүргүүлэх; 	<p>Худалдан авах ажиллагааны тайлан мэдээг хуулийн хугацаанд дээд шатны байгууллагад тайлагнасан байна.</p>	<p>ХААХ</p>	<p>ТӨБЗГ-т зохион байгуулагдаж байгаа улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны тайланг Сангийн сайдын 2018 оны 281 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам-ын 3.1-д заасны дагуу хагас, бүтэн жилээр тайлагнаж байна. Худалдан авах ажиллагааны 2018 оны жилийн эцсийн тайланг ТӨБЗГ-ын 2019 оны А-1/80 дугаартай албан бичгээр, 2019 оны эхний хагас жилд зохион байгуулсан худалдан</p>

	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд ил тод мэдээлэх; - I/15-ны дотор. 			<p>авах ажиллагааны тайланг 2019 оны А-1/2333 дугаартай албан бичгээр тус тус Сангийн яаманд хүргүүлэн тайлагнасан.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>
<p>Арга хэмжээ 3.6.7 (46)</p> <p>Орон нутгийн худалдан авах ажиллагаа хариуцсан нэгжүүдийн худалдан авах ажиллагааны 2019 оны төлөвлөгөөг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын цахим хуудсанд ил тод зарлан, өрсөлдөх тэгш боломж нөхцөлийг бүрдүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Худалдан авах ажиллагааны нэгжүүдэд зохион байгуулагдах төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны мэдээллийн нэгдсэн сан бий болгох; - Газрын цахим хуудсанд байршуулан мэдээллийн ил тод байдлыг хангах; - I сард. 	Худалдан авах ажиллагааны мэдээллийн ил тод, нээлттэй байдал хангагдсан байна.	3X3X	<p>21 аймгийн Орон нутгийн өмчийн газарт 2019 онд нийт дүнгээр 265.8 тэрбум төгрөгийн 1383 (100 хувь) төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөгдсөн. Төлөвлөгдсөн 1383 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг эх үүсвэрээр нь харуулбал:</p> <ul style="list-style-type: none"> – Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 125.5 тэрбум төгрөгийн 102 (7.0 хувь) төсөл, арга хэмжээ; – Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 54.1 тэрбум төгрөгийн 484 (35.0 хувь) төсөл, арга хэмжээ; – Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 60.1 тэрбум төгрөгийн 483 (35.0 хувь) төсөл, арга хэмжээ; – Сангийн хөрөнгө оруулалтаар 14.6 тэрбум төгрөгийн 232 (17.0 хувь) төсөл, арга хэмжээ; – Урсгал зардлаар 2.3 тэрбум төгрөгийн 23 (2.0 хувь) төсөл, арга хэмжээ; – Бусад хөрөнгө оруулалтаар 9.2 тэрбум төгрөгийн 59 (2.0 хувь) төсөл, арга хэмжээ байна. <p>Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах үүднээс 21 аймгийн худалдан авах ажиллагааны 2019 оны төлөвлөгөөг байгууллагын цахим хуудас www.pcsp.gov.mn сайтад байршуулсан.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн - 100%)</p>
<p>Арга хэмжээ 3.6.8 (47)</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд орон нутгийн нэгжийн зохион байгуулсан 2019 оны худалдан авах ажиллагааны</p>	<ul style="list-style-type: none"> - Орон нутгийн нэгжүүдийн зохион байгуулсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнг нэгтгэн холбогдох байгууллага болон олон нийтэд мэдээлэх; - Дээрх ажлын үр дүнг удирдлагуудад тайлагнах, - Тайлангийн мөрөөр авах арга хэмжээг тодорхойлж, 	Орон нутгийн нэгжүүд худалдан авах ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан байна.	3X3X	<p>Тайлант хугацаанд, 21 аймгийн орон нутгийн өмчийн газар, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газрын 2018 оны худалдан авах ажиллагааны жилийн эцсийн тайлан, мэдээг хүлээн авч нэгтгэл хийсэн. 2018 оны жилийн эцсийн байдлаар 734.9 тэрбум төгрөгийн 7204 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, 137.0 тэрбум төгрөгийн төсвийн хэмнэлт гарсан байна. Зохион байгуулагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийн үүсвэрийг ангилбал:</p> <ul style="list-style-type: none"> – Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 178.7 тэрбум төгрөгийн 336 төсөл, арга хэмжээ; – Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 332.8 тэрбум

<p>төлөвлөгөөний биелэлт, тайланг нэгтгэн гаргаж, дүнг удирдлагуудад танилцуулж, холбогдох байгууллагад хүргүүлэх</p>	<p>зохион байгуулах; - Улирал бүр.</p>			<p>төгрөгийн 1857 төсөл, арга хэмжээ; – Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 49.9 тэрбум төгрөгийн 625 төсөл, арга хэмжээ; – Сангийн хөрөнгө оруулалтаар 23.4 тэрбум төгрөгийн 360 төсөл, арга хэмжээ; – Зээл тусламжийн хөрөнгө оруулалтаар 42.0 тэрбум төгрөгийн 67 төсөл, арга хэмжээ; – Урсгал зардлаар 54.2 тэрбум төгрөгийн 2823 төсөл, арга хэмжээ; – Өөрийн хөрөнгө оруулалтаар 4.0 тэрбум төгрөгийн 153 төсөл, арга хэмжээ; – Бусад хөрөнгө оруулалтаар 49.6 тэрбум төгрөгийн 989 төсөл, арга хэмжээ.</p> <p>Зохион байгуулагдсан 7204 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны 7.1 хувь буюу 518 төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад Сангийн яам, Шүүх, Авлигатай тэмцэх газар, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газарт тендерт оролцогч аж ахуйн нэгжээс гомдол гаргасан байна.</p> <p>Худалдан авах ажиллагааны орон нутгийн нэгжийн 2019 оны эхний хагас жилийн тайлан мэдээг Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-д заасны дагуу 7 дугаар сарын 15-ны өдрийн дотор тайлагнахаар нэгтгэл хийж байна.</p> <p>(Хэрэгжих шатанд - 70%)</p>
<p>Арга хэмжээ 3.6.9 (48) Худалдан авах ажиллагааны “Цахим шалгалт”-ын системийн хэвийн үйл ажиллагааг хангах, цахим сургалт зохион байгуулах, худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн сертификаттай иргэдийн мэдээллийн санг</p>	<p>- Цахим шалгалтын системийн хэвийн үйл ажиллагааг хангах; - Шалгалтыг улсын хэмжээнд 100 хувь цахим хэлбэрээр зохион байгуулах; - Гэрчилгээ эзэмшигч (А3)-ийн мэдээллийг цахим санд оруулж, баяжилт хийх, ил тод мэдээлэх; - Сар бүр.</p>	<p>Худалдан авах ажиллагааг зохион байгуулах Үнэлгээний хорооны гишүүдийн чадавх сайжирсан байна.</p> <p>Шалгалтыг улсын</p>	<p>МТА, ХААХ</p>	<p>2019 оны 06 дугаар сарын 12-ны байдлаар “Цахим шалгалт”-ын системээр нийт 288 шалгалт зохион байгуулагдаж, худалдан авах ажиллагааны суурь мэдлэг олгох сургалтад хамрагдсан 6640 хүн шалгалт өгснөөс 3746 суралцагч тэнцсэн мэдээлэлтэй байна.</p> <p>Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн А3 гэрчилгээтэй төрийн албан хаагчид, иргэдийн жагсаалтаас цахим тендер зарлагдахаас өмнө Үнэлгээний хороог байгуулсан байх ба Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга тендерийн нээлтийг хийж, үнэлгээг хийх боломж цахим системийн хувьд бүрдсэн. Иймээс худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ бүхий этгээдийн жагсаалтыг тухай бүр шинэчилж, мэдээллийг цахим системд бүрэн оруулах ажлыг гүйцэтгэж байна.</p> <p>2019 оны 06 дугаар сарын 12-ны байдлаар худалдан авах</p>

баяжуулах		хэмжээнд 100 хувь цахим хэлбэрээр авсан байна.		ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ бүхий нийт 16159 албан хаагч, иргэний мэдээлэл төрийн худалдан авах ажиллагааны цахим системд бүртгэгдсэн байна. Цахим шалгалтын системийн үйл ажиллагааг сайжруулах, уян хатан, хэрэглэхэд амар хялбар болгох чиглэлээр нэмэлт тестчлэлийг хийж, шийдвэрлэх шаардлагатай асуудлуудын жагсаалтыг гарган зарим шаардлагатай өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. (Хэрэгжих шатанд – 70%)
<p>Арга хэмжээ 3.6.10 (49)</p> <p>Зарласан тендерийн нээлтийн болон үнэлгээний дараах үр дүн, гэрээ байгуулсан мэдээллийг олон нийтэд мэдээлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Тендерийн үнэлгээний хорооны нарийн бичгийн даргад нээлтийн кодыг илгээж, тендерийн баримт бичгийг татах, үнэлгээ хийх, үр дүн оруулах боломжоор хангах; - Худалдан авах ажиллагааны нээлтийн үр дүн, тендер шалгаруулалтын үр дүн, гэрээ байгуулсан тухай мэдээллийг олон нийтэд мэдээлэх; - Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргын цахим системд ажиллах чадавхийг сайжруулж, мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах; - Сар бүр. 	Худалдан авах ажиллагааны үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлсэн байна.	МТА	<p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ бүхий төрийн албан хаагчид, иргэдийн жагсаалтаас цахим тендер зарлагдахаас өмнө Үнэлгээний хороог байгуулсан байх ба Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга тендерийн нээлтийг хийж, үнэлгээг хийх боломж нөхцөл бүрдсэн. Энэ боломжийн хэвийн үйл ажиллагааг хангах, үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нарыг арга зүйгээр хангах ажлыг тогтмол хийж ажилласан.</p> <p>Тайлант оны эхний хагас жилийн байдлаар, тус системээр улсын хэмжээнд нийт 8328 тендер шалгаруулалтын үр дүн олон нийтэд мэдээлэгдсэн байна. Үүнээс 3069 нээлтийн, тендер шалгаруулалтын 4947 үр дүн гарсныг мэдээлсэн бол хянан үзсэн 259, бусад 53 төлөвтэй үр дүн мэдээлэгдсэн. Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем https://www.tender.gov.mn –д нийт 3079 гэрээ бүртгэгдсэн мэдээлэлтэй байна.</p> <p>(Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 3.6.11 (50)</p> <p>Худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн системийн хэвийн үйл ажиллагааг хангах, захиалагч байгууллагуудын</p>	<ul style="list-style-type: none"> - ТБОНӨХБАҮХАТХуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т заасны дагуу захиалагч байгууллагуудын худалдан авах ажиллагааны 2019 оны төлөвлөгөөг ТЕЗ болон төсвийн асуудал эрхэлсэн төрийн 	Захиалагч байгууллагын төлөвлөгөө олон нийтэд ил тод нийтлэгдэж, түүнд хийсэн өөрчлөлт, хэрэгжилтийн	МТА	<p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем https://www.tender.gov.mn -д 1835 захиалагч байгууллагын хэрэгжүүлэх 23653 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн талаарх мэдээлэл бүртгэгдэж, олон нийтэд мэдээлэгдсэн. Үүнээс ТӨБЗГ-ын төлөөлөл хэрэгжүүлдэг төрийн өмчит хуулийн этгээдэд зохион байгуулах 2745 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн талаарх мэдээлэл уг системд нийтлэгдсэн байна.</p> <p>Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журмын дагуу</p>

<p>төлөвлөгөөг олон нийтэд мэдээлэх</p>	<p>захиргааны төв байгууллагаар баталгаажуулж, олон нийтэд мэдээлэх;</p> <ul style="list-style-type: none"> - Захиалагч байгууллагыг мэргэшил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах; - Сар бүр. 	<p>мэдээлэлд дүн шинжилгээ хийгдэнэ. Худалдан авах ажиллагааны тайлан гарах боломжтой болсон байна.</p>		<p>ТӨБЗГ-ын төлөөлөл хэрэгжүүлдэг төрийн өмчит хуулийн этгээдийн худалдан авах ажиллагааны тайлан, төлөвлөгөөг хүлээн авч, 01 дүгээр сарын 15-ны байдлаар Сангийн яаманд хүргүүлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журамд заасан хугацааг мөрдөөгүй буюу хугацаа хоцорч ирүүлсэн төрийн өмчит хуулийн этгээдийн тайлан, төлөвлөгөөг нэгтгэх, төрийн худалдан авах ажиллагааны цахим системд буй өгөгдөлтэй тулган нягтлах ажлыг зохион байгуулсан. Энэ чиглэлээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг арга зүйн удирдлагаар хангаж ажиллав. (Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 3.6.12 (51)</p> <p>“Цахим тендер шалгаруулалт”-ын системийн хэвийн үйл ажиллагааг хангах, худалдан авах ажиллагааны төлөвлөлтийн дагуу урилгыг олон нийтэд мэдээлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг эхлүүлж, урилгыг олон нийтэд мэдээлэх; - Тендерийн үнэлгээний хороог баталгаажуулж, нарийн бичгийн даргын эрхийг шилжүүлж, тендерийн урилга нийтлэх боломжоор хангах; - Захиалагч байгууллагын төлөөлөл болон үнэлгээний хорооны нарийн бичгийн даргыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах; - Сар бүр. 	<p>Тендер шалгаруулалтын үйл ажиллагаа ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, хэмнэлттэй, хариуцлагатай болсон байна.</p>	<p>МТА</p>	<p>Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем https://www.tender.gov.mn –ийг улсын хэмжээнд хэвийн ашиглах, цахим худалдан авах ажиллагааг зохион байгуулах техникийн нөхцлийг хангах чиглэлээр системийн хэрэглэгчдийн чадавхийг дээшлүүлэхэд анхаарч ажилласнаар 2019 оны эхний хагас жилд төрийн худалдан авах ажиллагааны цахим систем https://www.tender.gov.mn –ээр улсын хэмжээнд нийт 9765 төсөл, арга хэмжээний тендерийн урилга зарлагдсанаас “Цахим тендер шалгаруулалт”-ын урилга 9555 зарлагдсан нь нийт урилгын 97.0 хувийг эзэлж байна.</p> <p>ТӨБЗГ-ын төлөөлөл хэрэгжүүлдэг төрийн өмчит хуулийн этгээдэд зохион байгуулах 841 тендерийн урилга цахим системээр зарлагдсан бөгөөд цахим тендер шалгаруулалтын урилга 820 буюу энэ нь нийт зарласан тендерийн 97.0% хувийг эзэлж байна.</p> <p>(Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 3.6.13 (52)</p> <p>Тендер шалгаруулалттай холбоотой гарсан гомдлын мэдээллийг ил</p>	<ul style="list-style-type: none"> - Тендер шалгаруулалттай холбоотой гарсан гомдлыг Сангийн яам бүртгэж, хуулийн хугацаанд гарсан шийдвэрээ олон нийтэд 	<p>Тендер шалгаруулалтын талаар гарсан гомдлын мэдээллийг олон нийтэд</p>	<p>МТА</p>	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2019 оны 3 дугаар сард нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотойгоор дараах журмыг боловсруулах ажлын хэсэгт ТӨБЗГ-ын төлөөлөл ажилласан бөгөөд Сангийн сайдын тушаалаар уг журмууд батлагдаад байна:</p> <p>– “Тендерт оролцогчоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх</p>

<p>тод болгох</p>	<p>мэдээлэх үйл ажиллагааг нэвтрүүлэх; - Жилдээ.</p>	<p>нээлттэй мэдээлэх боломж бүрдэнэ.</p>		<p>журам” (Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан), – “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендер оролцогчдод ил болгох журам” (Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан).</p> <p>“Худалдан авах ажиллагааны улсын байцаагчийн дүрэм”, “Тендер оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэл хөтлөх журам”-ын төслийг боловсруулах ажлын хэсгийг Сангийн яамнаас байгуулсан бөгөөд уг төслийг боловсруулж байгаа. Эдгээр нь журмын төсөлд олон нийтээс санал авахаар төрийн худалдан авах ажиллагааны цахим систем https://www.tender.gov.mn –д нээлттэй байршуулав.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан шинээр батлагдсан журам, заавар, аргачлалд нийцүүлэн тендерийн материал, тендер шалгаруулалттай холбоотой гомдол шийдвэрлэлтийг ил болгох, тендерийн баталгааны маягт, тендерийн жишиг баримт бичигт өөрчлөлт оруулах ажлыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн түвшинд хийж, бэлэн байдлыг хангасан.</p> <p>(Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 3.6.14 (53) Гэрээний гүйцэтгэлийн тухай мэдээллийг ил тод болгох</p>	<p>- Гэрээ байгуулагдсан үр дүнг нийтэлсний дараа гэрээний гүйцэтгэлд хяналт тавих байгууллага гүйцэтгэгчээс гүйцэтгэлийн мэдээллийг системд оруулах; - Олон нийтэд мэдээлэх үйл ажиллагааг нэвтрүүлэх; - Жилдээ.</p>	<p>Тендер шалгаруулалтад шалгарсан этгээдийн гэрээний гүйцэтгэлийн тухай мэдээллийг ил тод болгож, олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байна.</p>	<p>МТА</p>	<p>Тайлант хугацаанд, төрийн худалдан авах ажиллагааны цахим систем https://www.tender.gov.mn –д нийт 3079 гэрээ бүртгэгдсэн мэдээлэлтэй байна. (Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Дөрөв. “Захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, хууль, эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээлэл, технологийн хөгжлийг хангах” гэсэн стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</p>				

ХӨТӨЛБӨР VII “Төрийн болон орон нутгийн өмчийн харилцаа, худалдан авах ажиллагаанд хууль, эрх зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, бүтцийн нэгжүүдийн уялдаа холбоог хангаж, захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд:				
<p>Арга хэмжээ 4.7.1 (54)</p> <p>Шинээр батлагдах, шинэчлэн найруулах, өөрчлөлт оруулах хууль, дүрэм, журмын төслийн талаар санал боловсруулах</p>	<ul style="list-style-type: none"> - Холбогдох судалгаа хийх; - Төсөл боловсруулах; - Төсөлд албан хаагчдаас санал авах; - Холбогдох байгууллагад хүргүүлэх; - Жилдээ. 	<p>Хууль эрх зүйн орчин боловсронгуй болсон байна.</p>	<p>ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА</p>	<p>ТӨБХХ-ын хэлтсийн дарга Ц.Түвшинзаяа, ТӨБХХ-ын ахлах мэргэжилтэн Д.Нарангэрэл, Э.Ганчимэг нар Үндэсний аудитын газрын 20 гаруй аудитортай 2019 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр уулзалт хийж, төрийн өмчийн эд хөрөнгийн харилцааг зохицуулсан хууль, журамд тусгагдсан асуудлаар хэлэлцүүлэг хийж, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний талаар сургалт зохион байгуулсан. Энэ уулзалтын явцад Үндэсний аудитын газраас холбогдох журмын төсөлд тусгах санал ирүүлэхээр тохиролцсоны дагуу 2019 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 01/67 дугаар албан бичгээр холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай санал ирүүлсэн.</p> <p>Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-г хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлыг Засгийн газарт танилцуулсны дүнд Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоолоор “Хуулийн этгээдийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад төрийн өмчийн хөдлөх хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх эсэх асуудлыг тухай бүр хэлэлцэн шийдвэрлэж байхыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт зөвшөөрсөн” шийдвэр гаргасан.</p> <p>ТӨБЗГ-ын даргын 2019 оны А/101, А/102 дугаар тушаалаар “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”, “Дуудлагын худалдааны талаар авах арга хэмжээний тухай” 2016 оны 128 дугаар тогтоолыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгүүдийг байгуулан ажиллуулж, уг журам, тогтоолыг боловсронгуй болгон ТӨБЗГ-ын 260, 268, 269, 271 дүгээр тогтоолоор тус тус баталсан. Мөн ТӨБЗГ-ын даргын 2019 оны А/100, А/103 дугаар тушаалаар “Төрийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгөд оруулах хөрөнгө оруулалтын зөвшөөрөл олгох, хяналт тавих, хүлээн авах, тооцож баталгаажуулах ажлыг зохион байгуулах журам, “Түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар”, “Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журам”-ыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг тус тус байгуулан ажиллуулж байна. Эдгээр журмыг шинэчлэн боловсруулах хүрээнд журмын төслийг холбогдох яамд, байгууллагад хүргүүлж, санал авах арга хэмжээ авсан.</p> <p>Мөн Сангийн яамнаас боловсруулсан “Худалдан авах ажиллагааны</p>

				<p>мэргэшсэн ажилтан бэлтгэх, гэрчилгээ олгох журам"-ын төсөл, "Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам"-ын төсөл, Сонгуулийн ерөнхий хорооноос боловсруулсан "Сонгуулийн автоматжуулах хэрэгслийн иж бүрдлийг худалдан авах журам"-ын төсөлд А-1/245, А-1/1290, А-1/878 дугаартай албан бичгээр тус тус санал хүргүүлсэн.</p> <p>(Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 4.7.2 (55)</p> <p>Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх эрх зүйн актад нэмэлт, өөрчлөлт оруулах</p>	<ul style="list-style-type: none"> - Ажлын хэсэг байгуулах; - Шинэчлэн, шинээр боловсруулах, нэмэлт өөрчлөлт оруулах эрх зүйн актын жагсаалт гаргах; - Эрх зүйн актын төсөл боловсруулах; - Төсөлд албан хаагчдаас санал авах; - Даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, газрын даргын тушаалаар батлах, II улиралд; - Хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, жилдээ. 	<p>Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн хэрэгжилт хангагдсан байна.</p>	<p>ЗХЗХ, Ажлын хэсэг</p>	<p>Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам"-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, байгууллагын дотоод сүлжээгээр дамжуулан нийт албан хаагчдад танилцуулан санал авч, ТӨБЗГ-ын даргын 2019 оны А/163 дугаар тушаалаар батлан мөрдүүлж эхлэв.</p> <p>"Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг"-ийн төслийг боловсруулж, батлуулахаар ТӨБЗГ-ын даргын 2019 оны А-1/991 дугаартай албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.</p> <p>Түүнчлэн, "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар", "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн ёс зүйн дүрэм"-д тус тус өөрчлөлт оруулахаар төсөл боловсруулж байна.</p> <p>(Хэрэгжилт хангалтгүй - 30%)</p>
<p>Арга хэмжээ 4.7.3 (56)</p> <p>Газрын дотоод аудитын үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө боловсруулах, батлуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Төлөвлөгөөний төслийг боловсруулах, I сард; - Даргын тушаалаар батлах, I сард; - Албан хаагчдад танилцуулан, ил тод мэдээлэх; - Дотоод аудитын үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах, тайлагнах, - Жилдээ. 	<p>Байгууллагын үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага сайжирна.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дотоод аудитын 2019 оны төлөвлөгөөг нийт 7 ажил гүйцэтгэхээр боловсруулж, газрын даргын 2019 оны А/50 дугаар тушаалаар батлан хэрэгжилтийг хангаж байна. Уг төлөвлөгөөг байгууллагын дотоод сүлжээ www.able.mn –д байршуулан нийт албан хаагчид мэдээлсэн. Тайлант хугацаанд тус төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шилэн дансны хэрэгжилтэд хяналт тавьж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд аудит хийв. Мөн цаг үеийн шаардлага, удирдлагын шийдвэрээр төрийн өмчит үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх үйл ажиллагааны зохицуулалт, албан бичиг, өргөдөл гомдлын хугацаа хэтрэлтийн байдалд тус тус дотоод аудит хийж, тайланг Даргын</p>

				<p>зөвлөлийн хуралдаанд танилцуулсан.</p> <p>Дотоод аудитын хүрээнд хийгдсэн дээрх ажлуудын тайлан, зөвлөмжийг байгууллагын дотоод сүлжээ www.able.mn –ээр дамжуулан нийт албан хаагчдад танилцуулсан.</p> <p>(Хэрэгжих шатанд - 70%)</p>
<p>Арга хэмжээ 4.7.4 (57)</p> <p>Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал боловсруулж, хэрэгжүүлэх хэмжээ авах</p>	<ul style="list-style-type: none"> - Санал боловсруулж, газар, хэлтэс, албаны удирдлагад танилцуулах, I улиралд; - Хэрэгжүүлэх арга хэмжээ авах; - Олон улсын байгууллага, холбогдох бусад байгууллагатай, хамтарч ажиллах, жилдээ. 	<p>Гадаад хамтын ажиллагаа өргөжсөн байна.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхээр Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD), Дэлхийн банк (WB), Европын сэргээн босголт хөгжлийн банк, Казакстан улсын Сангийн яамны харьяа Төрийн өмч, хувьчлалын хороо, Германы хамтын ажиллагааны байгууллага (GIZ), Швейцарийн хамтын ажиллагааны байгууллага (SWISS Cooperation Agency), Туркийн хамтын ажиллагааны байгууллага (TIKA), Солонгосын хамтын ажиллагааны байгууллага (KOICA), Казакстан улсын төрийн өмчит хөрөнгө оруулалтын сан Самрук Казына зэрэг байгууллагатай холбоо тогтоохоор ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас 2019 оны 9 дүгээр сарын 4, 5-ны өдрүүдэд Филиппин улсын Манила хотод зохион байгуулагдах “Төрийн өмчит хуулийн этгээдийн Компанийн засаглалын Азийн Сүлжээний 12 дахь удаагийн уулзалт”, 2019 оны 10 дугаар сарын 17-18-ны өдрүүдэд Франц улсын Парис хотноо зохион байгуулагдах “Төрийн өмчлөл ба хувьчлалын туршлага” Ажлын Хорооны 33 дахь удаагийн уулзалтад оролцох урилга, хөтөлбөрийг хүлээн аваад байна. Уг уулзалт, арга хэмжээнд тус байгууллагын төлөөллийг оролцуулахаар бэлтгэж байна. (Хэрэгжих шатанд - 70%)</p>
<p>Арга хэмжээ 4.7.5 (58)</p> <p>Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнах</p>	<ul style="list-style-type: none"> - Хэлтэс, албанаас санал авч, төлөвлөгөөг боловсруулах, II сард; - Төлөвлөгөөний төсөлд холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигатай тэмцэх газрын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээг тусгах; - Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах 	<p>Авлигын эсрэг хуулийн хэрэгжилт хангагдсан байна.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Засгийн газрын 2017 оны 114 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 17 арга хэмжээг хяналтад авч хэрэгжүүлэн ажиллаж, АТГ-т тогтоосон хугацаанд тайлагнав. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 2018 оны жилийн эцсээр 87.5 хувийн гүйцэтгэлтэй дүгнэж, 2019 оны А-1/671 дугаартай албан бичгээр АТГ-т хүргүүлсэн. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 17 арга хэмжээг байгууллага, хэлтсийн 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж байна. Авлигын эсрэг хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд “Авлигын эсрэг сургалт, соён гэгээрүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөө”-ний төсөл боловсруулж, саналыг А-1/794 дугаартай</p>

	<p>арга хэмжээ авах, хэрэгжилтийн явцад хяналт тавих, жилдээ;</p> <ul style="list-style-type: none"> - Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилтийн тайланг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх, II сард. 			<p>албан бичгээр АТГ-т хүргүүлэн зөвшилцөж, хамтарсан төлөвлөгөө батлан хэрэгжүүлж байна. 2019 онд нийт 13 төрлийн сургалт, арга хэмжээ зохион байгуулж, ТӨБЗГ, түүний харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн давхардсан тоогоор 1301 албан хаагчийг хамруулахаар төлөвлөснөөс эхний хагас жилд давхардсан тоогоор төрийн өмчит 70 хуулийн этгээд, байгууллагын нийт 781 албан хаагчийг авлигын эсрэг сургалтад хамруулав.</p> <p>Үндэсний хөтөлбөрийн 2018 оны хэрэгжилтийн дүнтэй холбоотойгоор АТГ-ын 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 01/4939 дугаартай албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг 2019 оны сүүлийн хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. (Хэрэгжих шатанд - 70%)</p>
<p>Арга хэмжээ 4.7.6 (59)</p> <p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг харьяа хуулийн этгээдэд хэрэгжүүлэхэд зөвлөмж, чиглэлээр хангах, хяналт тавьж ажиллах</p>	<ul style="list-style-type: none"> - Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд чиглэл, зөвлөмж хүргүүлэх; - Харьяа 3-5 хуулийн этгээдийн мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг шалгах, заавар, зөвлөмж, арга зүйгээр хангах, жилдээ. 	<p>Зөвлөмжийн хэрэгжилтэд ахиц гарч, харьяа байгууллагад авлигын эсрэг үйл ажиллагааны зохион байгуулалт сайжирсан байна.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 01/8836 дугаар албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн “Авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж”, 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 05/11047 дугаар албан бичгээр ТӨБЗГ-т ирүүлсэн чиглэл зөвлөмжийн хэрэгжилтийг хангуулахаар хэлтэс, алба, нийт албан хаагчдад зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав.</p> <p>Мөн ТӨБЗГ-аас төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд 2018 оны А-1/2869, 2019 оны А-1/04 дугаартай албан бичгээр хүргүүлсэн зөвлөмж, албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авав.</p> <p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах хүрээнд хуулийн байгууллагаар тогтоогдсон, авлигын гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан нөхцлийг арилгах арга хэмжээ авах, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг мөрдөх талаар тодорхой арга хэмжээ авч, ТӨБЗГ-ын даргын 2019 оны 01 дүгээр албан даалгавар (15 заалт бүхий)-ыг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой нийт 72 компани, үйлдвэрийн газарт хүргүүлэн хугацаатай үүрэг даалгавар өгөв. Тус албан даалгаврын хэрэгжилт, үр дүнг улирал тутам тайлагнах үүргийг компани, үйлдвэрийн газрын гүйцэтгэх удирдлагад даалгаснаас 2019 оны 1-р улирлын тайланг 12, 2 дугаар улирлын тайланг 3 хуулийн этгээд ирүүлж, нийт 32 хуулийн этгээдийн 1026 албан хаагч авлигын эсрэг хуулийн холбогдох хориглолт хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллахаа амлан</p>

				<p>баталгаа гаргасан байна.</p> <p>Тайлант хугацаанд, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ, “Орхон АЗЗА” ТӨХК-д ажиллаж, мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны ажилтай танилцан, мэдээлэл, арга зүйгээр хангаж, шалган туслах ажлыг гүйцэтгэв.</p> <p>Авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах хүрээнд нийт 336 албан хаагчид зөвлөгөө, мэдээлэл өгсөн. (Бүрэн хэрэгжсэн - 100%)</p>
<p>Арга хэмжээ 4.7.7 (60)</p> <p>Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Авлигын эсрэг сургалтын хэрэгцээг тодорхойлох судалгаа хийх, I сард; - Сургалтын төлөвлөгөөний төслийг хэлтэс, албанаас санал авч боловсруулах; - Авлигатай тэмцэх газартай хамтарсан төлөвлөгөө батлах, II сард; - Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангах, жилдээ. 	<p>Авлигын эсрэг сургалтад ТӨБЗГ болон харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн нийт 561 албан хаагчийг хамруулсан байна. Үүнээс анхан шатны сургалтад 265, давтан сургалтад 296 албан хаагчийг хамруулна.</p>	<p>3Х3Х</p>	<p>Авлигын эсрэг сургалт, соён гэгээрүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөөг Авлигатай тэмцэх газартай хамтран баталж хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг төлөвлөгөөнд тусгаснаар 2019 онд нийт 13 төрлийн сургалт, арга хэмжээг хамтран зохион байгуулж, түүнд ТӨБЗГ, орон нутгийн нэгж, төрийн өмчит хуулийн этгээдийн давхардсан тоогоор 1301 албан хаагчийг хамруулахаар төлөвлөсөн. Эхний хагас жилд нийт 491 албан хаагчийг ёс зүйн болон авлигын эсрэг суурь мэдлэг олгох сургалтад хамруулсан Үүнд: ТӨХЭ-ийн 57 захирал, нягтлан бодогч нарыг ёс зүйн сургалтад, Орон нутгийн өмчийн газрын 77 албан хаагч, АТГ-ын Олон нийтийн төвд төрийн өмчит 11 хуулийн этгээдийн 201 албан хаагчийг авлигын эсрэг суурь сургалтад, Орхон аймагт зохион байгуулсан сургалтад 8 хуулийн этгээдийн 156 албан хаагчийг тус тус хамруулсан байна. (Хэрэгжих шатанд - 70%)</p>
<p>Арга хэмжээ 4.7.8 (61)</p> <p>Авлигын эсрэг хууль тогтоомжид заасан мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлыг хуулийн хугацаанд бүрдүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангах, тайлан мэдээг гаргаж, холбогдох байгууллагад тайлагнах</p>	<ul style="list-style-type: none"> - Мэдүүлэг гаргагчдаас мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг гаргахад шаардлагатай хууль, тогтоомжийг таниулах арга хэмжээг зохион байгуулах, жилдээ; - Мэдүүлгийг цахимаар мэдүүлэх боломж нөхцөлөөр хангах; - Мэдүүлгийг баталгааны хуудсаар хүлээж авах, цахим системд баталгаажуулалт хийх, бүртгэл хөтлөх, жилдээ; 	<p>Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хүлээсэн үүрэг хэрэгжиж,</p>	<p>3Х3Х</p>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар болон түүний төлөөлөл хэрэгжүүлдэг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 49 хуулийн этгээдийн мэдүүлэг гаргагч албан тушаалтны 2018 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болн хөрөнгө орлогын мэдүүлэг (ХАСХОМ)-ийг хуулийн хугацаанд буюу 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор шинэчлэн мэдүүлэх, мөн мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2018 оны тайлан, мэдээг боловсруулах ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллав. Нийт 701 мэдүүлэг гаргагч албан тушаалтан 2018 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд мэдүүлэн цахим системд баталгаажуулсан, хугацаа хоцроосон, мэдүүлэг гаргаагүй тохиолдол гараагүй. ТӨБЗГ болон түүний төлөөлөл хэрэгжүүлдэг төрийн өмчит хуулийн этгээдийн 2018 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн тайланг хянаж, нэгтгэн 2019 оны А-1/431 дугаартай албан бичгээр Авлигатай тэмцэх газарт</p>

	<ul style="list-style-type: none"> - Тайлан-мэдээг холбогдох хууль, журам, зааврын дагуу гаргах, нэгтгэл хийж, дүгнэн мэдээлэх; - Мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2018 оны тайлан, мэдээг хуулийн хугацаанд АТГ-т хүргүүлэх, III/01-ний өдрийн дотор. 	<p>тайлан, мэдээллийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.</p>		<p>хуулийн хугацаанд хүргүүлэв.</p> <p>ТӨБЗГ-т хийгдэж байгаа 2019 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн ажлын явцын мэдээ, эхний хагас жилийн дүнгээр:</p> <p>1.Албан тушаалд нэр дэвшигчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан 82 мэдүүлэг (ХАСУМ)-ийг хүлээн авч, АТГ-т хянуулсан байдал:</p> <ul style="list-style-type: none"> - ТӨБЗГ-ын албан тушаалд нэр дэвшигч – 8; - ТӨХЭ-ийн захиралд нэр дэвшигч – 7; - ТӨБЗГ-ын албан хаагчдаас ТУЗ-д төлөөлөл хэрэгжүүлэхээр нэр дэвшигч – 20; - Бусад төрийн байгууллагаас ТУЗ-д төлөөлөл хэрэгжүүлэхээр нэр дэвшигч – 33; - ТУЗ-д хараат бус гишүүнээр нэр дэвшигч – 14. <p>2.Мэдүүлэг гаргагч албан тушаалтны гаргасан нийт 133 ХАСХОМ-ийг хүлээн авч, цахим системд баталгаажуулсан. ХАСХОМ-ийг гаргасан төрлөөр танилцуулбал,</p> <ul style="list-style-type: none"> - Шинэчлэн гаргасан (2018) – 113 (ТӨБЗГ-50; ТӨХЭ-ийн захирал 63); - Албан тушаалд шинээр томилогдсон (2018*) – 15 (ТӨБЗГ-9; ТӨХЭ-ийн захирал 6); - Хөрөнгө орлогод нь их хэмжээний өөрчлөлт орсон (2018+) – 5 (ТӨБЗГ-3; ТӨХЭ-ийн захирал 2). <p>Мэдүүлэг, мэдэгдэл тайлбар гаргахад шаардлагатай хууль сурталчлах, таниулах арга хэмжээний хүрээнд нийт 262 албан тушаалтанд мэдээлэл, зөвлөгөө өгч, арга зүйгээр хангасан байна.</p> <p>ХАСУМ, ХАСХОМ, АСМ-ийг хүлээн авсан бүртгэлийг тус бүрд нь хууль тогтоомжид заасан зааврын дагуу гүйцэтгэж, мэдээ, тайлан гаргаж байна. Мөн цахим бүртгэлийг мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем https://meduuleg.iaac.mn –д хийж байна.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн - 100%)</p>
<p>Арга хэмжээ 4.7.9 (62)</p> <p>Үнэлгээний хорооны гишүүд, шаардлагатай албан тушаалтнаас “Ашиг сонирхлын</p>	<ul style="list-style-type: none"> - Үнэлгээний хорооны гишүүдийн АСМ, тайлбар гаргаж байгаа байдалд хяналт тавьж, бүрэн гаргуулах, нээлттэй байдлыг хангах арга 	<p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах,</p>	<p>ЗХЗХ</p>	<p>2019 оны эхний хагас жилийн байдлаар нийт 66 АСМ хүлээн авч, АТГ-ын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим систем https://meduuleg.iaac.mn –д бүртгэсэн. Үүнээс 1 АСМ нь захиргааны шийдвэр гаргахад ашиг сонирхлын зөрчил үүссэн тухайгаа, 65 нь худалдан авах ажиллагааг бэлтгэх, зохион байгуулахад ашиг</p>

<p>зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл” (АСМ), тайлбарыг гаргуулан хүлээн авч, мэдэгдэл, тайлбарын мэдээллийг АТГ-ын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд бүрэн оруулах</p>	<p>хэмжээг авах; - Мэдэгдэл, тайлбарын бүртгэл хөтлөх; - АСМ-ийг АТГ-ын мэдүүлгийн бүрдүүлэлтийн цахим системд мэдээллийг оруулах; - Тайлан, мэдээнд холбогдох мэдээллийг тусгах; - АСМ, тайлбар гаргасан байдалд дүгнэлт хийх, улирал, жилдээ.</p>	<p>ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна.</p>		<p>сонирхлын зөрчил үүсээгүй болохыг мэдэгдсэн байна.</p> <p>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасны дагуу гаргасан нийт 52 АСМ-ийг шилэн дансны цахим систем https://shilendans.gov.mn –нд нийтэлж мэдээлсэн байна.</p> <p>ТӨБЗГ-т зохион байгуулж байгаа худалдан авах ажиллагааны үнэлгээний хорооны гишүүдээс холбогдох хууль тогтоомжийн дагуу ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухай мэдэгдэл, тайлбар (АСМ) гаргаж байгаа байдалд эхний хагас жилийн байдлаар хяналт тавьж, дүгнэлт хийв. Тендерийн үнэлгээний ажил дуусч, гэрээ байгуулсан эсвэл гэрээ байгуулах мэдэгдэл хүргүүлсэн нийт 28 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хорооны гишүүдийн давхардсан тоогоор 140 АСМ бүртгэгдэхээс 13 үнэлгээний хорооны гишүүдийн 65 мэдэгдэл бүртгэгдсэн байна. Эдгээрээс дүгнэхэд, худалдан авах ажиллагааг зохион байгуулахад гаргавал зохих нийт АСМ-ийн 46.0 хувь нь бүртгэгдсэн, 37.1 хувь нь шилэн дансны цахим хуудсанд нээлттэй мэдээлэгдсэн байна. Иймээс сүүлийн хагас жилд мэдэгдэл, тайлбарын бүрдүүлэлтийг эрчимжүүлэх талаар холбогдох хэлтэст чиглэл, зөвлөмж өгөв.</p> <p>АСМ-ийн бүрдүүлэлтийн талаар 7 хоног, сар бүрийн мэдээ, тайланд тусган мэдээлж байгаа болно. (Хэрэгжих шатанд - 70%)</p>
<p>Арга хэмжээ 4.7.10 (63)</p> <p>Хууль, шүүхийн байгууллагад үүссэн хэрэг, маргаанд байгууллагыг төлөөлж нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцох, тайлбар мэдүүлэг, нотлох баримт гаргаж өгөх</p>	<p>- Хэрэг, маргааныг хууль хяналтын байгууллагаар шийдвэрлүүлэхэд холбогдох албан хаагчдын уялдаа холбоог хангаж, хамтран ажиллах; - Хэрэг, маргааны талаар судалж, санал боловсруулах, удирдлагын түвшинд хэлэлцэж, шийдвэрлэх арга хэмжээ авах; - Хуулийн хүрээнд хэрэг, маргааныг шийдвэрлүүлсэн байх; - Хэрэг, маргааны</p>	<p>Хэрэг, маргааны шийдвэрлэлт ахисан байна. Шинээр хэрэг, маргаан бүртгэгдсэн тоо цөөрсөн байна.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Тайлант хугацаанд, худалдан авах ажиллагаатай холбоотой 5, өмчийн харилцаатай холбоотой 11, албан тушаалын томилгоотой холбоотой 2, нийт 18 маргаан шүүхэд хянагдаж байгаагаас захиргааны 7, иргэний 8, эрүүгийн 2, арбитрын 1 хэрэг маргаан байна.</p> <p>Дээрх хэрэг маргааны хянан шийдвэрлэх ажиллагаанд тайлбар мэдүүлэг, нотлох баримт гаргаж өгөх, ТӨБЗГ-ыг хууль, шүүхийн байгууллагад төлөөлөн оролцсон. Тайлант хугацаанд хэрэг маргааны шийдвэрлэгдсэн байдлыг танилцуулбал, нэхэмжлэлээ татан авсан 2, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон 1, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, зарим хэсгийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн 1, нэхэмжлэлийн шүүхээс буцаасан 1, нийт 5 хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн байна.</p> <p>2019 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар, арбитрын шүүхэд 1, анхан шатны шүүхэд 10, давж заалдах шатны шүүхэд 1,</p>

	<p>шийдвэрлэлтийн талаар дүгнэлт, тайлан боловсруулж, тайлагнах, тухай бүр;</p> <ul style="list-style-type: none"> - Хэрэг, маргаан шинээр гаргахгүй байх арга хэмжээ авч хэрэгжүүлэх, жилдээ. 			<p>дээд шүүхэд 1, нийт 13 хэрэг шүүхэд хянагдаж байна. ТӨБЗГ нь хянагдаж байгаа нийт 13 хэргийн 2-т нэхэмжлэгчээр, 2-т хохирогчоор, 9-т хариуцагчаар оролцож байгаа ба хэргийн явцын талаарх мэдээллийг цаг тухай бүр удирдлагад танилцуулж, мэдээ тайланд тусган мэдээлсэн. (Бүрэн хэрэгжсэн - 100%)</p>
<p>Арга хэмжээ 4.7.11 (64)</p> <p>ТӨБЗГ-ын тогтоол, тушаал, албан бичиг, бусад баримт бичгийн төслийг хууль, эрх зүйд нийцүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Шинээр боловсруулж байгаа баримт бичгийн төслийн эрх зүйн үндэслэлийг хянаж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх арга хэмжээ авах, өдөр тутамд; - Хянасан баримт бичиг, эрх зүйн актын бүртгэл хөтлөх, өдөр тутамд; - Тайлан, мэдээнд тусгаж, тайлагнах, сар, улирал, жилдээ. 	<p>Эрх зүйн зөрчилтэй шийдвэр, баримт бичиг батлагдаагүй байна.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэх 299 асуудлын төсөл, 271 тогтоол, 20 тэмдэглэл, 251 тушаал болон албан бичиг, тендерийн баримт бичиг, урилга, мэдэгдэл, тайлан зэрэг баримт материалын төслийн хууль зүйн үндэслэлийг хянаж, хуульд нийцүүлэн боловсруулах, албажуулахад дэмжлэг үзүүлсэн. Мөн газрын албан хаагчдад хууль зүйн туслалцаа хүссэн тухай бүр асуудлыг судалж, зохих зөвлөгөөг өгч ажилласан. (Бүрэн хэрэгжсэн - 100%)</p>
<p>Арга хэмжээ 4.7.12 (65)</p> <p>Дээд шатны байгууллагаас батлан гаргасан холбогдох бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, тайлагнан мэдээлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Тогтоол шийдвэрийн хяналтад авсан заалтын судалгааг нарийвчлан гаргах, хагас, бүрэн жилд; - Шинээр хяналтад авсан бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулалтаар хангах, тухай бүр; - Хэлтэс, албанаас хариуцсан шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах, мэдээллийг нэгтгэн боловсруулах, хагас, бүтэн жилд; - Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын 	<p>Байгууллагын үйл ажиллагаанд хамааралтай холбогдох бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг дээд шатны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна.</p>	<p>ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА</p>	<p>Тайлант хугацаанд, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2018 оны жилийн эцэс, 2019 оны эхний хагас жилийн тайланг нэгтгэн боловсруулж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн дүгнэж, Засгийн газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллагад хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд тайлагнасан.</p> <p>Дээрх бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн дүнг дор товч танилцуулав:</p> <ol style="list-style-type: none"> 1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн дүн: <ul style="list-style-type: none"> - 2018 оны жилийн эцсийн дүн: Нийт 22 заалтын тухайн жилийн зорилтот түвшингийн хэрэгжилт 90.0 хувь; - 2019 оны эхний хагас жилийн дүн: 22 заалтын тухайн жилийн зорилтот түвшингийн хэрэгжилт 84.1 хувь. 2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн

	<p>баримт бичиг болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг хэрэгжүүлж, тогтоосон хугацаа, хуваарийн дагуу дээд шатны байгууллагад тайлагнах;</p> <p>- Цахим систем, дотоод сүлжээгээр олон нийт, албан хаагчдад мэдээлэх, тухай бүр.</p>			<p>хэрэгжилтийн дүн:</p> <ul style="list-style-type: none"> - 2018 оны жилийн эцсийн дүн: Нийт 4 зорилт, арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь; - 2019 оны эхний хагас жилийн дүн: 2 зорилт арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь. <p>3.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн дүн:</p> <ul style="list-style-type: none"> - 2018 оны жилийн эцсийн дүн: Нийт 7 төрлийн 67 шийдвэрийн 114 заалтын хэрэгжилт 95.1 хувь; - 2019 оны эхний хагас жилийн дүн: Нийт 7 төрлийн 50 шийдвэрийн 87 заалтын хэрэгжилт 85.4 хувь. <p>Эдгээр бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн дүн тус бүрийг холбогдох журмын дагуу Даргын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн эрчимжүүлэх шаардлагатай зорилт, арга хэмжээ, заалтын талаар холбогдох хэлтэс, алба, албан хаагчдад тэмдэглэлээр үүрэг өгч, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай тайлан, зөвлөмжийг дотоод сүлжээнд байршуулан албан хаагчдад танилцуулах арга хэмжээ авав. Тайлан тус бүрийг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан http://unelgee.gov.mn -нд оруулж, Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамруулсан болно.</p> <p>Мөн тайлант хугацаанд, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг 2018 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэн дүгнэж тайланг 2019 оны А-1/671 дугаартай албан бичгээр АТГ-т хуулийн хугацаанд хүргүүлсэн. Уг үндэсний хөтөлбөрт тусгагдсан 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх нийт 17 заалт бүхий арга хэмжээний хэрэгжилт 87.5 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн болно.</p> <p>Засгийн газрын газраас 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарласантай холбоотой Засгийн газрын 2019 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх арга хэмжээ авч, улирал бүр хэрэгжилтийн тайланг гарган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байна. Уг жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хамаарал бүхий 21 арга хэмжээний хэрэгжилт I улирлын байдлаар 49.1 хувийн гүйцэтгэлтэй байсан бол II улирлын дүнгээр 67.9 хувь болж, хэрэгжилт 18.8 хувиар ахисан дүнтэй байна.</p>
--	--	--	--	--

				(Бүрэн хэрэгжсэн - 100%)
<p>Арга хэмжээ 4.7.13 (66)</p> <p>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн сургалтын хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Албан хаагчдын 2019 оны сургалтын төлөвлөгөө боловсруулах, батлах, I сард; - Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, жилдээ; - Төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах, улиралд. 	Газрын албан хаагчдын мэдлэг, ур чадвар дээшилж, байгууллагын чадавх сайжирна.	ЗХЗХ	<p>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын 2019 оны сургалтын төлөвлөгөө”-ний төслийг хэлтэс, албадын саналыг тусган 22 сургалт зохион байгуулахаар боловсруулж, газрын даргын 2019 оны А/48 дугаар тушаалаар батлан, байгууллагын дотоод сүлжээ www.able.mn -нд байршуулан албан хаагчдад танилцуулсан. Тус төлөвлөгөөний дагуу эхний хагас жилд дараах сургалтуудыг зохион байгуулж, нийт албан хаагчдыг хамруулсан:</p> <ol style="list-style-type: none"> 1. “Мэдлэгийн менежментийн хүрээлэн”-гийн захирал П.Мөнхтогтоор “Харилцааны урлаг” сэдвээр, илтгэгч нь “Мэдлэгийн менежментийн хүрээлэн”-гийн захирал П.Мөнхтогт; 2. “Иргэн бүрд олгосон 1072 хувьцаа” сэдвээр, илтгэгч нь “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн мэдээллийн төвийн албаны дарга Б.Батбаяр, мэргэжилтэн Г.Бямбацэрэн нар; 3. “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх нь” сэдвээр, илтгэгч нь Архивын ерөнхий газрын сургагч багш Л.Дэлгэрцэцэг; 4. “Захиргааны хэм хэмжээний акт” сэдвээр, илтгэгч нь Хууль зүй дотоод хэргийн яамны ахлах мэргэжилтэн Д.Алтантуяа. <p>Мөн Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Төрийн албаны зөвлөл, Авлигатай тэмцэх газар, Архивын ерөнхий газар, Удирдлагын академи зэрэг байгууллагуудаас зохион байгуулсан 14 удаагийн сургалтад давхардсан тоогоор 50 гаруй албан хаагчийг хамруулж мэдлэг, мэргэшлийг дээшлүүлж, 3 албан хаагчийг Удирдлагын академийн төрийн захиргааны менежментээр мэргэшүүлэх сургалтад Засгийн газрын тэтгэлгээр суралцуулж байгаа бөгөөд 3 албан хаагчийг өөрийн зардлаар их, дээд сургуульд суралцах боломжоор ханган дэмжлэг үзүүлж байна.</p> <p>(Хэрэгжих шатанд - 70%)</p>
<p>Арга хэмжээ 4.7.14 (67)</p> <p>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг</p>	<ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийг 2019 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулах, батлах; - Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, жилдээ; 	Газрын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах тодорхой ажлууд	ЗХЗХ	<p>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд гэр бүлд нь шинээр хүүхэд мэндэлсэн 3 албан хаагчид тус бүр 100.0 мянган төгрөг, ар гэрт нь гачигдал тохиолдсон 2 албан хаагчид тус бүр 200.0 мянган төгрөг, шинээр гэр бүл болсон 1 албан хаагчид 200.0 мянган төгрөгийн тусламж, хүндээр өвдсөн 1 албан хаагч, эцэг, эх, гэр бүлийн гишүүн нь хүндээр өвдсөн 3 албан хаагчид тус бүр 1</p>

хэрэгжүүлэх	- Төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах, улиралд.	хийгдсэн байна.		<p>сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг байгууллагын дотоодод мөрдөж байгаа холбогдох журмын дагуу тус тус олгож, Эх үрсийн баярыг тохиолдуулан албан хаагчдын нийт 102 хүүхдэд 2.1 сая төгрөгийн бэлэг өгөв.</p> <p>Улсын Хоёрдугаар төв эмнэлгээр үйлчлүүлэх ТӨБЗГ-ын албан тушаалтны жагсаалтыг гарган ТӨБЗГ-ын даргын 2019 оны А-1/1036 дугаар албан бичгээр Улсын Хоёрдугаар төв эмнэлэгт, ТӨБЗГ-ын албан хаагчид болон өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настнуудыг үзлэг шинжилгээнд хамруулах талаар хамтран ажиллах тухай хүсэлтийг 2019 оны А-1/1034 дугаар албан бичгээр Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт тус тус хүргүүлсэн.</p> <p>Төрийн захиргааны 31 албан хаагчид зэрэг дэв шинээр болон шинэчлэн олгож, 7 албан хаагчийг төрийн алба хаасан хугацааны нэмэгдэлд хамруулсан.</p> <p>Цагаан сарын баяр, Ардын хувьсгалын 97 жилийн ой, үндэсний их баяр наадмыг тохиолдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт үр бүтээлтэй ажиллаж, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан 1 албан хаагчийг “Гавъяат эдийн засагч”, 2 албан хаагчийг “Алтан гадас” одонгоор, 4 албан хаагчийг “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар, 3 албан хаагчийг салбарын “Хүндэт жуух” бичгээр, 5 албан хаагчийг Залуучуудын холбооны шагналаар шагнуулахаар тодорхойлон холбогдох материалыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, салбарын яам, Монголын залуучуудын холбоонд тус тус хүргүүлэв. Мөн Цагаан сарын баярыг тохиолдуулан 22 ахмад настанг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулав. (Бүрэн хэрэгжсэн - 100%)</p>
<p>Арга хэмжээ 4.7.15 (68)</p> <p>2018 оны “Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлан”-г Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх</p>	<p>- Албан хаагчдын мэдээллийг Төрийн албаны зөвлөлийн мэдээллийн санд бүртгэх;</p> <p>- Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайланг тогтоосон хугацаанд Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх, тайлагнах, I улиралд.</p>	Тайланг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн байна.	ЗХЗХ	<p>2018 оны “Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлан”-г хүний нөөцийн системд оруулан, мэдээллийг 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр, явцын өөрчлөлтийн мэдээг 2019 оны 03 дугаар сарын 29-ний өдөр Төрийн албаны зөвлөлд тус тус хүргүүлэн баталгаажуулсан. (Бүрэн хэрэгжсэн - 100%)</p>

<p>Арга хэмжээ 4.7.16 (69)</p> <p>Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, батлах</p>	<ul style="list-style-type: none"> - Ажлын хэсэг байгуулах, III сард; - Байгууллагын чиг үүргийн шинжилгээ хийх, III-IV сард; - Холбогдох журамд заасан шинжилгээ, дүгнэлт хийх; - Холбогдох мэдээлэл цуглуулах; - Албан тушаалын тодорхойлолтуудыг боловсруулж, холбогдох материалын хамт Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн хянуулж, батлах зөвшөөрөл авах; - Албан тушаалын тодорхойлолтыг батлах, VI сард. 	<p>Төрийн албанд хэрэгжүүлэх “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангасан байна.</p>	<p>ЗХЗХ, Ажлын хэсэг</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор баталсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ыг мөрдөх, байгууллага, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахтай холбоотойгоор “Байгууллагын стратеги төлөвлөгөө боловсруулах, чиг үүргийн болон ажлын байрны шинжилгээ хийх, гүйцэтгэлийн болон албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсэг”-ийг ТӨБЗГ-ын даргын 2019 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/86 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Тус ажлын хэсэг Засгийн газрын 2018 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан “Чиг үүрэг дахин хуваарилах аргачлал”-ын дагуу чиг үүргийн шинжилгээг хэлтэс, алба бүрээр хийж чиг үүргийн давхардал, хийдлийг судлан, дүгнэлт гарган, “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-ын дагуу агентлагийн даргын албан тушаалын тодорхойлолтын төсөл, бусад холбогдох материалыг боловсруулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Байгууллагын албан тушаалын бусад тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахаар бэлтгэж байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт 2019 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжихтэй холбоотойгоор тус байгууллагын бүтцэд өөрчлөлт орох шаардлага үүсч байгаа тул албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах ажлыг хойшлуулаад байна.</p> <p>(Хэрэгжилт хангалтгүй - 30%)</p>
<p>Арга хэмжээ 4.7.17 (70)</p> <p>Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж эхэлсэнтэй холбоотой шинэчлэн батлагдсан журам, зааврыг сурталчлан таниулах, хэрэгжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Журам, зааврыг албан хаагчдаар судлуулах арга хэмжээ авах; - Журам, зааврыг сурталчлан таниулах сургалт, семинар зохион байгуулах; - Журам, зааврын хэрэгжилтийг хангах; - Жилдээ. 	<p>Төрийн албаны стандарт, журам, дүрмийн хэрэгжилт хангагдана.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга) хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан байгууллагын дотоод сүлжээ www.able.mn – ээр дамжуулан нийт албан хаагчдад танилцуулан, санал авч төсөлд тусгах арга хэмжээ авав. Уг журмыг ТӨБЗГ-ын даргын 2019 оны А/163 дугаар тушаалаар батлан мөрдүүлж эхэлсэн. Мөн Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбоотойгоор УИХ, Засгийн газар, Төрийн албаны зөвлөлөөс шинээр болон шинэчлэн баталсан журам, заавар, бусад актын судалгааг гаргаж, тэдгээрт нийцүүлэн байгууллагын дотоодод мөрдөж байгаа “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн ёс зүйн дүрэм”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын шагналын журам”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчид тусламж, тэтгэмж, нөхөн</p>

				<p>олговор олгох журам”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын зөвлөлийн ажиллах журам”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах журам”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн сургалтын хөтөлбөр”, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг шинэчлэн боловсруулж байна.</p> <p>(Хэрэгжилт хангалтгүй - 30%)</p>
<p>ХӨТӨЛБӨР ҮИИ “Хүний нөөцийн чадавхийг сайжруулж, хэлтэс, албан хаагчдын гүйцэтгэл, үр дүнг дээшлүүлэх, сахилга, хариуцлагыг өндөржүүлэх” хөтөлбөрийн хүрээнд:</p>				
<p>Арга хэмжээ 4.8.1 (71) Газар, хэлтэс, албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангуулах, тайлагнах зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэрэгжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Байгууллага, хэлтэс, албаны ажлыг төлөвлөх, гүйцэтгэлийг тайлагнах чиглэлээр албан хаагчдыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр хангаж, сургалт зохион байгуулах, III сард; - Хэлтэс, албаны 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлах, I/5, YII/5-ны өдрийн дотор (хагас жил тутамд); - Хэлтэс, албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах, улиралд; - Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, тайлагнах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, хагас, бүтэн жилд; - Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг гаргах, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхэд бэлтгэх, XII/30-ны өдрийн дотор; - Байгууллагын 2020 оны 	<p>Байгууллага, хэлтэс, албаны үйл ажиллагааны зохион байгуулалт сайжирч, гүйцэтгэл, үр дүнд чанарын ахиц гарна. Хариуцлагын тогтолцоо бий болж, байгууллагын стратегийн зорилт, хууль тогтоомжоор хүлээсэн үүргийн хэрэгжилт хангагдах боломж бүрдэнэ.</p>	<p>ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА</p>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, хэлтэс, албаны гүйцэтгэлийн төлөвлөгөөг бодлогын баримт бичигтэй уялдуулан үр дүнгийн гэрээний загварын дагуу (гүйцэтгэлийн төлөвлөгөө, үнэлгээ, тайлан гаргах заавар, аргачлал маягтыг Засгийн газар батлахаар зохицуулагдсан бөгөөд тус аргачлал батлагдаагүй тул) боловсруулж газрын даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ТӨБЗГ болон түүний зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд 2019 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлийн хэрэгжилтийг гарган явцын хяналт-шинжилгээ хийж байна. (Хэрэгжих шатанд - 70%)</p>

	гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд хэлтэс, албанаас санал авч, нэгтгэн боловсруулах, батлах, XII сард.			
<p>Арга хэмжээ 4.8.2 (72)</p> <p>Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан, хэрэгжилтэд хяналт тавих, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх ажлыг зохион байгуулалтаар хангаж, холбогдох журмыг хэрэгжүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Албан хаагчдад гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэл, үр дүнг үнэлэх асуудлаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, холбогдох журам, заавар, аргачлалыг судлуулах ажлыг зохион байгуулах, III сард; - Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хянан батлах, I/10-ны өдрийн дотор; - Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний явцад хяналт тавьж, тайланг баталгаажуулах, сар бүрийн 3-ны өдрийн дотор; - Албан хаагчдын 2019 оны гүйцэтгэлийг үнэлэх “Байгууллагын үнэлгээний баг” байгуулах, үнэлгээг холбогдох журмаар тогтоосон хугацаанд хийх бэлтгэл хангах, XII сард. 	Албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинд ахиц гарна. Гүйцэтгэл, тайлагналын чанар сайжирч, төрийн албан хаагчийн хариуцлага дээшилнэ.	ЗХЗХ, БТУХ, ТӨБХХ, ХААХ, МТА	<p>Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга), Засгийн газрын 2019 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын дагуу албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөг жил болон улирлаар төлөвлөж сар бүр тайлагнаж байхаар зохицуулагдсан боловч гүйцэтгэлийн төлөвлөгөө, үнэлгээ, тайлан гаргах заавар, аргачлал маягтыг Засгийн газар батлахаар зохицуулагдсан бөгөөд тус аргачлал батлагдаагүй тул албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сар бүр дүгнээгүй.</p> <p>Төрийн албаны тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ЗГХЭГ-аас НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад мэргэжлийн, төрийн албыг төлөвшүүлэх нь” төслийн дэмжлэгтэй зохион байгуулсан “Стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг төрийн захиргааны байгууллагад нэвтрүүлэх нь” сэдэвт сургалтад 2 албан хаагчийг хамруулсан бөгөөд нийт албан хаагчдад ЗГХЭГ-тай хамтран сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна. (Хэрэгжилт хангалтгүй - 30%)</p>

<p>Арга хэмжээ 4.8.3 (73)</p> <p>Байгууллагын албан хаагчдад шаардлагатай эрх зүйн туслалцаа үзүүлж, зөвлөгөө, мэдээллээр хангах, хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Шаардлагатай үед хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх; - Ажилтнуудад шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгөх; - Дагаж мөрдөх дүрэм, журмыг танилцуулж, тайлбарлах; - Албан хаагчдын 2019 оны сургалтын төлөвлөгөөнд тодорхой сэдвийг тусгах, I сард; - Тухай бүр. 	<p>Албан хаагчид хариуцсан ажлын чиглэлээр хууль, эрх зүйн зөрчилгүй ажилласан байна.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдаанаар хэлэлцүүлэх 299 асуудлын төсөл, 271 тогтоол, 20 тэмдэглэл, 251 тушаал болон албан бичиг, тендерийн баримт бичиг, урилга, мэдэгдэл, тайлан зэрэг баримт материалын төслийн хууль зүйн үндэслэлийг хянаж, хуульд нийцүүлэн боловсруулах, албажуулахад дэмжлэг үзүүлсэн. Мөн газрын албан хаагчдад хууль зүйн туслалцаа хүссэн тухай бүр асуудлыг судалж, зохих зөвлөгөөг өгч ажилласан.</p> <p>Албан хаагчдын 2019 оны сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх, албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглүүлэн “Захиргааны хэм хэмжээний акт” сэдвээр сургалт зохион байгуулж, Хууль зүй, дотоод хэргийн яамны ахлах мэргэжилтэн Д.Алтантуяаг урьж лекц уншуулав. (Хэрэгжих шатанд - 70%)</p>
<p>Арга хэмжээ 4.8.4 (74)</p> <p>Газрын хүний нөөцийн асуудлаар судалгаа хийх</p>	<ul style="list-style-type: none"> - Хүний нөөцийн талаар зохих судалгаа хийх; - Удирдлагыг мэдээллээр хангах; - Мэдээллийн сан бүрдүүлэх; - Судалгааны мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, зохион байгуулах; - Жилдээ. 	<p>Байгууллагын хүний нөөцийн мэдээллийн сан үүсч, мэдээлэл, судалгааны үндсэн дээр хүний нөөцийг чадавхижуулах, нийгмийн баталгааг хангах чиглэлээр тодорхой арга хэмжээ авахад ашигласан байна.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын хэрэгжилтийг хангах болон 2020 оны төсвийн төсөл боловсруулах ажлын хүрээнд албан хаагчдын зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн судалгаа, албан хаагчдын 2019 оны ээлжийн амралт олгох ажлын хүрээнд ажилласан жилийн судалгаа, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хаагчдын орон сууцны хөтөлбөр”-ийн төсөл боловсруулах ажлын хүрээнд албан хаагчдын орон сууцны судалгаа зэргийг гаргаж, хүний нөөцийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд үндэслэл болгон ашиглав. Мөн “Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайлан”-г шинэчлэн Төрийн албаны зөвлөлд, төрөөс хөнгөлөлттэй зээлээр их, дээд сургуульд суралцсан албан хаагчдын талаарх судалгааг гарган Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Зээлийн санд, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж буй эсэхийг талаарх судалгааг Төрийн албаны зөвлөлд, сайжруулсан шахмал түлшний хөнгөлөлтөд хамрагдах албан хаагчдын судалгааг гарган “Таван толгой түлш” ХХК-д тус тус хүргүүлсэн.</p> <p>(Хэрэгжих шатанд - 70%)</p>
<p>Арга хэмжээ 4.8.5 (75)</p> <p>Албан хаагчдын хариуцлагыг чангатгаж,</p>	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авах; - Хөдөлмөрийн дотоод журам, байгууллагын хэмжээнд 	<p>Албан хаагчдын сахилга хариуцлага</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Албан хаагчдын гүйцэтгэл, үр дүн, бүтээмжийг сайжруулах, сахилга хариуцлагыг чангатгах зэрэг асуудлыг тодорхой болгох зорилгоор дотоод журам, дүрмийг тодотгох, шинэчлэн боловсруулах ажлыг хийж байна. Тайлант хугацаанд, “Төрийн өмчийн бодлого,</p>

<p>хууль тогтоомж зөрчсөн, зөрчил, дутагдал гаргасан албан хаагчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоог тодорхой болгож, хэрэгжилтийг хангах</p>	<p>мөрдөгдөх бусад журам, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж, хариуцлагын тогтолцоог тодорхой болгох зохицуулалтыг хийх;</p> <ul style="list-style-type: none"> - Зөрчил, дутагдал гаргасан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу тухай бүр хариуцлага тооцох; - Зөрчил, дутагдал гаргаж, хариуцлага хүлээсэн албан тушаалтны талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлэх; - Жилдээ. 	<p>өндөржиж, байгууллагын дотоод зохион байгуулалт сайжирна.</p>		<p>зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам"-ыг шинэчлэн боловсруулж, албан хаагчдын саналыг авч тусган ТӨБЗГ-ын даргын 2019 оны А/163 дугаар тушаалаар батлан мөрдүүлж байна. Мөн "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар"-т нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын Зөвлөлийн хуралдаанд танилцуулсан бөгөөд саналыг тусган албажуулахаар бэлтгэж байна. 2019 оны эхний хагас жилийн байдлаар ажлын болон ажлын бус цагаар ажлын байр, томилолтын явцад согтууруулах ундаа хэрэглэсэн, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаагүй, удирдлагын зөвшөөрөлгүйгээр ажлын байр орхин явсан зөрчил гараагүй. (Бүрэн хэрэгжсэн - 100%)</p>
<p>Арга хэмжээ 4.8.6 (76)</p> <p>Албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, ажлын байрны дэг журмыг чанд сахих талаар арга хэмжээ зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Албан хаагчдын цаг ашиглалт, дэг журмыг сайжруулах асуудлаар дотоод журамд нэмэлт, өөрчлөлт оруулан батлах, мөрдүүлэх, I улиралд; - Албан хаагчдын цаг бүртгэлийн мэдээг долоо хоног бүр цаг бүртгэлийн системээс гаргах; - Удирдлагад танилцуулах; - Ажилд хоцорсон болон цаг ашиглалт хангалтгүй албан хаагчид хариуцлага тооцох, жилдээ. 	<p>Албан хаагчдын ажлын цаг ашиглалтад тавих хяналт сайжирч, ажлын хариуцлага, албан хаагчдын бүтээмж нэмэгдэнэ.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>"Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам"-ыг газрын даргын 2019 оны А/163 дугаар тушаалаар шинэчлэн баталж, мөрдүүлэн ажиллаж байна. Уг журмын 9.2.4-д "Албан хаагч нь нэг сард хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 8 цагаас дээш хугацаагаар хоцорсон, бүртгүүлээгүй тохиолдолд 1 өдрийн ажил тасалсанд тооцно", 9.2.7-д "Захиргаа, хууль зүйн нэгж нь албан хаагчийн цагийн бүртгэлийг системийн дагуу баталгаажуулах бөгөөд уг бүртгэл нь цалин хөлсийг тооцох үндэслэл болно", 9.2.8-д "Албан хаагч нь сард 1 өдөр ба түүнээс дээш хугацаагаар ажил тасалсан нь түүнд сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" зэрэг өөрчлөлтийг оруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн албан хаагчдын цагийн бүртгэлийг 7 хоног бүр газрын шуурхайд танилцуулж хэвшсэн бөгөөд албан хаагчийн ажлын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор албан хаагчдын ажлын байрандаа байгаа эсэхэд гэнэтийн үзлэг шалгалтыг 7 хоногт нэг удаа хийж хэвшсэн. Тайлант хугацаанд, ажлын цагийг үр бүтээлтэй ашиглаагүй, удирдлагын зөвшөөрөлгүйгээр ажлын байр орхин явсан зөрчил гараагүй байна. (Бүрэн хэрэгжсэн - 100%)</p>
<p>Арга хэмжээ 4.8.7 (77)</p> <p>Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл болон цалингийн шатлал нэмэгдүүлэх,</p>	<ul style="list-style-type: none"> - Албан хаагчдын нийгмийн даатгалын дэвтэр, холбогдох бичиг баримтыг үндэслэн судалгаа гаргах; - Албан хаагчдын ажилласан жилийн баталгаажуулалт хийх; 	<p>Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, холбогдох журмын дагуу</p>	<p>ЗХЗХ</p>	<p>ЗГХЭГ-ын даргын 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 135, ЗГХЭГ-ын Тэргүүн дэд даргын 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 158 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах арга хэмжээ авч, 31 албан хаагчид зэрэг дэв шинээр болон шинэчлэн олгож, 7 албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон.</p> <p>Албан хаагчдын зэрэг дэв, төрийн алба хаасан хугацааны</p>

албан тушаалын зэрэг дэв олгох асуудлыг шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, цалингийн шатлал ахиулах, албан тушаалын зэрэг дэв нэмэгдэх албан хаагчийн судалгаа гаргах; - Санхүүгийн тооцоо, төсөөлөл боловсруулах; - Тушаалын төсөл боловсруулах, албажуулах; - Хэрэгжилтийг хангах; - 1 дүгээр сард. 	албан хаагчдын нийгмийн баталгааны зарим асуудал шийдвэрлэгдсэн байна.		нэмэгдлийн судалгааг шинэчлэн гаргаж, 2019 онд “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын дагуу 5 албан хаагчид зэрэг дэв шинээр олгуулах хүсэлтийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Л.Оюун-Эрдэнэд 2019 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А-1/351 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. (Хэрэгжих шатанд - 70%)
--	---	--	--	---

ХӨТӨЛБӨР IX

“Мэдээллийн технологийн ололтыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх замаар менежментийг сайжруулж, байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах” хөтөлбөрийн хүрээнд:

<p>Арга хэмжээ 4.9.1 (78)</p> <p>Гадаадын улс орнуудын худалдан авах ажиллагааны болон төрийн өмчийн бүртгэл хяналтын системийн цаашдын хөгжил, чиг хандлага, хууль, эрх зүй, технологийн шийдлийн талаар судалгаа хийж, сайн туршлагыг нэвтрүүлэх</p>	<ul style="list-style-type: none"> - Хөгжингүй орны мэдээллийн системийн харьцуулсан дүгнэлт хийх; - Шинэ ололт, чиг хандлага, сайн туршлагыг судлах; - Нэвтрүүлж болох сайн туршлагын талаар санал дэвшүүлэх; - Жилдээ. 	Хөгжлийн түвшинг харьцуулан тодорхойлсон байна. Дүгнэлт гаргасан байна.	МТА	<p>Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Шведийн вант улсын худалдан авах ажиллагаа, Ерөнхий гэрээ байгуулах ажлын туршлага судлуулахаар 3 албан хаагч 3 дугаар сард Швед улсад томилолтоор ажилласан. Тэдгээр албан хаагчид Швед улсын худалдан авах ажиллагааны газар (National Procurement Services), Шударга өрсөлдөөний газар (Swedish Competition Authority), Бүс нутгийн худалдан авах ажиллагааны газар (Central purchasing body), Сангийн яам зэрэг байгууллагын үйл ажиллагаатай танилцаж, ерөнхий гэрээ байгуулах, хэрхэн үр ашигтай худалдан авах ажиллагааг зохион байгуулж байгаа, давуу болон сул тал, цаашид анхаарах хүчин зүйлсийн талаар туршлага судалсан.</p> <p>2019 оны 04 сарын 22-ны өдөр Нээлттэй засгийн түншлэлийн Multi Donor Trust Fund-д Гэрээний хэрэгжилтийг ил болгох, нээлттэй гэрээний олон улсын стандартыг нэвтрүүлэх чиглэлээр төслийн санал боловсруулж хүргүүлсэн. (Хэрэгжих шатанд – 70%)</p>
<p>Арга хэмжээ 4.9.2 (79)</p> <p>Газрын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх, албан хаагчдад мэдээллийн технологийн орчин үеийн ололтыг ашиглахад чиглэсэн мэргэжил, арга зүйн</p>	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын дотоод болон гадаад сүлжээний хэвийн ажиллагааг хангах; - Байгууллагын техник, тоног төхөөрөмжийн ашиглалтыг сайжруулж, хэвийн ажиллагааг хангах; - Сар бүр. 	Байгууллагын дотоод болон гадаад сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа хангагдсан байна.	МТА	<p>Байгууллагын дотоод болон гадаад сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллан мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах чиглэлээр албан хаагчдын чадавхийг нэмэгдүүлэхэд анхааран, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, дэмжлэгээр байнга ханган ажиллаж байна. Дотоод сүлжээний программ хангамж, цаг бүртгэлийн систем, дотоод хяналтын камерын системийн үйл ажиллагаанд техникийн хяналт тавин ажиллав.</p> <p>(Бүрэн хэрэгжсэн – 100%)</p>

зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх				
Арга хэмжээ 4.9.3 (80) Албан хэрэгцээнд дотоод сүлжээний https://www.able.mn e-office системийн хэрэглээг сайжруулах	<ul style="list-style-type: none"> - Удирдлагын мэдээллийн нэгдмэл байдал хангагдах нөхцөл бүрдэх; - Ажлын уялдаа холбоо сайжирч, бүтээмж дээшилсэн байх; - Сар бүр. 	Албан хаагчдын ажлын бүтээмж, гүйцэтгэлд ахиц гарсан байна. Гүйцэтгэлд тавих хяналт сайжирна.	МТА	Албан хэрэгцээнд дотоод сүлжээний https://www.able.mn e-office системийн хэрэглээг сайжруулж, удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцооны хэвийн ажиллагааг ханган ажиллаж хэвшсэн. (Бүрэн хэрэгжсэн – 100%)
Арга хэмжээ 4.9.4 (81) Байгууллагын хяналтын камерын хэвийн жигд ажиллагааг хангах	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын дотоод хяналтын техник технологийн шийдлийг хөгжүүлэх; - Камерын системийг хэвийн ажиллуулах; - Сар бүр. 	Байгууллагын дотоод хяналт сайжирсан байна.	МТА	Байгууллагын хяналтын камерын хэвийн ажиллагааг ханган, дотоод хяналт тавин ажиллаж байна. (Бүрэн хэрэгжсэн – 100%)
ХӨТӨЛБӨР Х				
“Байгууллагын дотоод зохион байгуулалтыг сайжруулж, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах” хөтөлбөрийн хүрээнд:				
Арга хэмжээ 4.10.1 (82) Газрын хуралдаан, Даргын Зөвлөлийн хурал, бусад хурлын бэлтгэл ажил, зохион байгуулалтыг хангаж ажиллах	<ul style="list-style-type: none"> - Газрын хуралдаан болон бусад хурлын бэлтгэлийг хангах, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл, гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг бэлтгэх, холбогдох эрх бүхий албан тушаалтанд мэдээллийг хүргэх, ирцийг хангах; - Асуудал оруулах, хэлэлцүүлэх дэгийг боловсронгуй болгох; - Газрын хуралдаан болон бусад хуралдаанд оруулах асуудал, шийдвэрийн төслийг хянах, албажуулах; 	Газрын хуралдаан, Даргын Зөвлөлийн хурал, бусад хурлын зохион байгуулалтад чанарын ахиц өөрчлөлт гарсан байна.	ЗХЗХ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын ээлжит хуралдааныг 2019 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг”-ийн дагуу нийт 14 удаа (танхимд 13, санал авах хуудсаар 1) зохион байгуулж, 299 асуудал хэлэлцүүлэн, 270 тогтоол, 20 тэмдэглэлийг албажуулав. ТӨБЗГ-ын хуралдаанаас гаргасан 270 тогтоолыг агуулгаар нь ангилан харуулбал: 1. Эрх зүйн акттай холбоотой – 3; 2. Хуулийн этгээдийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц батлах тухай – 8; 3. Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин батлах тухай – 50; 4. Хуулийн этгээдийн удирдлагыг томилох, чөлөөлөх тухай – 8; 5. Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх асуудлаар – 14; 6. Хуулийн этгээдийн бусад асуудлаар – 8; 7. Өмч, хувьчлалын асуудлаар – 5; 8. Хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн асуудлаар – 150; 9. Шалгалтын дүн мөрөөр авах арга хэмжээний тухай – 24 шийдвэр

	<ul style="list-style-type: none"> - Хурлын тэмдэглэл хөтөлж, албажуулах; - Газрын хурлын шийдвэрийн ил тод байдлыг ханган байгууллагын цахим хуудсанд байршуулах; - Газрын тогтоол, хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлт, үр дүнг Газрын хуралдаан, Даргын Зөвлөлийн хуралд танилцуулах; - Жилдээ. 			<p>гарсан байна.</p> <p>Мэдээллийн ил тод байдлыг хангаж олон нийтэд мэдээлэх зорилгоор ТӨБЗГ-ын хуралдааны тогтоол шийдвэрийг газрын www.pcsp.gov.mn цахим хуудсанд байршуулж, эд хөрөнгө актлах, устгах, дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох асуудлаар гарсан тогтоол, тэмдэглэлийг сар бүр шилэн дансны цахим систем www.shilendans.gov.mn -д байршуулж, нээлттэй мэдээлсэн.</p> <p>“Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хуралдааны дэг”-д өөрчлөлт оруулах, орон тооны бус гишүүдэд урамшуулал олгох асуудлын төслийг боловсруулан ЗГХЭГ-т ТӨБЗГ-ын 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А-1/991 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын Зөвлөлийн хуралдааныг 2019 оны эхний хагас жилд 4 удаа хуралдуулж, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтийн тайлан, 2018 онд хэвлэл мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хийсэн дотоод аудитын тайлан, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хөдөлмөрийн дотоод журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төсөл, Төрийн дээд цол, одон, медальд албан хаагчдыг тодорхойлох асуудал, Албан бичиг, өргөдөл гомдлын хугацаа хэтрэлтийн байдалд хийсэн дотоод аудитын тайлан, Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, “Төрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг шилжүүлэх үйл ажиллагааны зохицуулалтад хийсэн дотоод аудитын тайлан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн зааварт өөрчлөлт оруулах тухай санал зэрэг байгууллагын дотоод үйл ажиллагааны асуудлуудыг хэлэлцэж, шийдвэрлэх арга хэмжээ аван ажиллав. (Хэрэгжих шатанд - 70%)</p>
<p>Арга хэмжээ 4.10.2 (83)</p> <p>Нэг цэгийн үйлчилгээний шуурхай, тасралтгүй байдлыг хангаж, үйлчилгээний чанарыг</p>	<ul style="list-style-type: none"> - Газрын чиг үүрэгтэй холбоотой мэдээ, мэдээлэл, зөвлөгөөг иргэн, хуулийн этгээдэд ил тод, шуурхай хүргэх; - Нэг цэгийн үйлчилгээгээр үзүүлсэн үйлчилгээний 	<p>Үйлчлүүлэгчид мэдээлэл, зөвлөгөөг шуурхай өгч, үйлчилгээний чанарт ахиц өөрчлөлт</p>	<p>ЗХЗХ</p>	<p>2019 оны эхний хагас жилд “Нэг цэгийн үйлчилгээ”-гээр давхардсан тоогоор нийт 9541 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээ үзүүлсэн байна. Үйлчилгээний тоон үзүүлэлтийг харуулбал:</p> <ul style="list-style-type: none"> - Зөвлөгөө өгсөн - 5767 (утсаар 3897, биечилж 1870); - Тендертэй холбоотой мэдэгдэл, тодруулга, саналын урилга хүргэсэн - 243;

дээшлүүлэх арга хэмжээ авах	<p>тоо, үзүүлэлт гаргах асуудлыг боловсронгуй болгох;</p> <ul style="list-style-type: none"> - Үйлчилгээний мэдээлэлд дүгнэлт хийж, удирдлага, албан хаагчдад мэдээлэх, тайлагнах; - Сар бүр. 	гаргасан байна.		<ul style="list-style-type: none"> - Тоон гарын үсгийн E-Токен код олгосон - 28; - Худалдан авах ажиллагааны суурь мэдлэг эзэмшигчийн гэрчилгээ (A3) олгосон – 1423; - Худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn -д аж ахуйн нэгж, байгууллагыг бүртгэн, баталгаажуулсан - 2080 байна. <p>(Хэрэгжих шатанд - 70%)</p>
<p>Арга хэмжээ 4.10.3 (84)</p> <p>Газрын үйл ажиллагааг хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд хүргэх, сурталчлах</p>	<ul style="list-style-type: none"> - Хэвлэл, мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулах, I улиралд; - Газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл бэлтгэх, фото зургийн болон мэдээллийн архив үүсгэх; - Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтлэх; - Газрын цахим хуудас, нүүр номын хуудсанд байршуулах, жилдээ; - Хэвлэлийн хурал зохион байгуулах, улирал бүр. 	Газрын үйл ажиллагааны талаарх мэдээлэл иргэд, олон нийтэд шуурхай хүрсэн байна.	3X3X	<p>2019 онд тендерийн урилга, зар, мэдээг нийтэлж, олон нийтэд нээлттэй мэдээлэх сониноор сонгогдсон Өнөөдөр, Зууны мэдээ, Засгийн газрын мэдээ, Ub post сонинтой хамтран ажиллах гэрээ байгуулж, 152 тендерийн урилгыг цаг тухайд нь нийтлүүлсэн.</p> <p>ТӨБЗГ-ын үйл ажиллагааг мэдээлэх, сурталчлан таниулах, мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор 2019 оны эхний хагас жилд байгууллагын цахим хуудас болон олон нийтийн цахим сүлжээнд 26 мэдээ, мэдээлэл, дуудлагын худалдааны, ТУЗ-ийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтын болон худалдан авах ажиллагааны зөвлөх үйлчилгээний нийт 7 зар, мэдээллийг байршуулан нээлттэй мэдээлэв.</p> <p>Мөн 26 мэдээ мэдээллийг бэлтгэн цахим хуудсаар 35, телевизээр 23, өдөр тутмын сониноор 5, радиогоор 2 удаа олон нийтэд хүргэж, 5 тодруулга ярилцлага, 3 нэвтрүүлэгт холбогдох албан хаагчийг оролцуулсан.</p> <p>Байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулах хүрээнд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Засгийн газрын 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэх, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн байгууллагын вэбсайтад тавих шаардлага MNS 6285:2017” стандартын шаардлагыг хангах зорилгоор тус газрын www.pcsp.gov.mn цахим хуудсыг шинэчилж байна. (Хэрэгжих шатанд - 70%)</p>
<p>Арга хэмжээ 4.10.4 (85)</p> <p>Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн батлах, байгууллагын</p>	<ul style="list-style-type: none"> - Байгууллагын хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын төслийг хэлтэс, албан хаагчдын саналыг үндэслэн боловсруулж, шинэчлэн 	Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион	3X3X	<p>Баримт бичиг нягтлан шалгах комиссын 2019 оны шийдвэрээр байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг байнга хадгалах 28, түр хадгалах 24, 70 жил хадгалах 1, нийт 53 хэрэг хөтлөгдөхөөр шийдвэрлэсэн.</p> <p>2019 онд “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив,</p>

<p>архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх</p>	<p>батлах; - Хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг мөрдүүлэх; - Архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө боловсруулах; - Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах; - Үзлэгт хамрагдах; - II улиралд.</p>	<p>байгуулалтын улсын үзлэгт “А” үнэлгээ авсан байна.</p>		<p>албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг” явагдахтай холбогдуулан тус үзлэгт бэлтгэх, төв болон салбар комиссыг үзлэг явуулахад дэмжлэг үзүүлэх, үзлэгт бэлдсэн ажлын талаар төв болон салбар комиссыг мэдээллээр хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/164 дүгээр тушаалаар байгуулан ажиллуулж, улсын үзлэгт бэлтгэж байна.</p> <p>(Хэрэгжилт хангалтгүй - 30%)</p>
<p>Арга хэмжээ 4.10.5 (86) Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн хэвийн үйл ажиллагааг зохион байгуулалтаар ханган ажиллах, албан бичгийн шийдвэрлэлтэд тавих дотоод хяналтыг сайжруулах</p>	<p>- Албан бичгийн шийдвэрлэлтэд www.able.mn дотоод сүлжээгээр дамжуулан бүртгэлээр хяналт тавих; - Хугацаатай албан бичгийг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах; - Шийдвэрлэгдээгүй албан бичгийн мэдээг удирдлагад танилцуулж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллах; - Албан хэрэг хөтлөлтийн стандарт, зааврын хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчил доголдлыг арилгах арга хэмжээг авах; - Жилдээ.</p>	<p>Байгууллагын албан хэрэг хөтлөлт, бичиг хэргийн стандарт, заавар журмын хэрэгжилт хангагдсан байна.</p>	<p>ЗХЗХ</p>	<p>Тайлант хугацаанд, байгууллагад 3463 (газрын удирдлага-11, ЗХЗХ-354 БТУХ-932, ТӨБХХ-1442, ХААХ-357, МТА-367) албан бичиг ирсэнийг дотоод сүлжээний www.able.mn системд бүртгэж, удирдлагын заалтын дагуу хариуцсан албан хаагчдад дотоод сүлжээгээр шилжүүлэн бүртгэлээр хяналт тавин ажиллаж байна. Нийт 3463 албан бичгээс хариутай 2003 албан бичиг ирсэн ба 1731 шийдвэрлэгдэж, 194 албан бичиг хяналтад байгаа ба 78 (ГУ-1 ЗХЗХ-13, БТУХ-18, ТӨБХХ-39, ХААХ-6, МТА-1) албан бичгийн шийдвэрлэх хугацаа хэтэрсэн байна. Хариугүй 1460 албан бичиг хүлээн авсан байна. Шийдвэрлэх хугацаа хэтэрч байгаа албан бичгийг шуурхай шийдвэрлэх сануулгыг 7 хоног бүр албан хаагчдад өгч, албан бичиг шийдвэрлэлтийн мэдээг гарган танилцуулж байна. Бусад байгууллага, хуулийн этгээдэд 2059 албан бичгийг албажуулан хүргүүлсэн байна. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 209, хүний нөөцтэй холбоотой 42, нийт 251 тушаалыг гарган хэрэгжилтийг хангах арга хэмжээ авав.</p> <p>Мөн 2019 оны 4 дүгээр сард “Албан бичиг, өргөдөл гомдлын хугацаа хэтрэлтэд дотоод аудит хийх” тухай удирдамжийг ТӨБЗГ-ын даргын тушаалаар баталж, аудит хийв. Аудитын тайланг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Даргын Зөвлөл болон нийт албан хаагчдад танилцуулж, холбогдох хууль, журам зааврыг мөрдөх ажлыг сайжруулж, “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааварт” өөрчлөлт оруулах талаар аудитын зөвлөмж өгсөн. Зөвлөмжийн дагуу “Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-т өөрчлөлт оруулах төслийг боловсруулан Төрийн өмчийн</p>

				бодлого, зохицуулалтын газрын Даргын Зөвлөлийн хуралдаанд танилцуулж, гарсан саналыг тусган, албажуулахаар бэлтгэж байна. (Хэрэгжих шатанд - 70%)
Арга хэмжээ 4.10.6 (87) Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, судлах, шийдвэрлүүлж, тайлагнах	<ul style="list-style-type: none"> - Өргөдөл, гомдлыг хүлээн авах, холбогдох албан хаагчид хүргүүлэх; - Шийдвэрлэлтийн байдалд хяналт тавьж, дүнг удирдлагад танилцуулах; - Байгууллагын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, тайланг гаргах; - Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаарх мэдээллийг газрын цахим хуудсаар олон нийтэд мэдээлэх; - Улирал бүр. 	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх талаарх хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	ЗХЗХ	2019 оны эхний хагас жилийн байдлаар Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт 102 өргөдөл, гомдлыг иргэдээс бичгээр хүлээн авч, байгууллагын дотоод сүлжээ www.able.mn -д бүртгэн, удирдлагын заалтын дагуу албан хаагчид хуваарилан хүргүүлж, бүртгэлээр хяналт тавин ажиллав. Бүртгэгдсэн нийт өргөдөл, гомдлоос шийдвэрлэгдсэн 86, шийдвэрлэгдэх хугацаа болоогүй 10, хугацаа хэтэрсэн, шийдвэрлэгдээгүй байгаа 5 (ЗХЗХ-1, БТУХ-3, ТӨБХХ-1) өргөдөл, гомдол байна. Мөн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, тайлан мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлж хэвшсэн бөгөөд тайлант хугацаанд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2018 оны жилийн эцэс, 2019 оны 1 дүгээр улирлын тайланг байгууллагын цахим хуудсанд байршуулж, 2019 оны эхний хагас жилийн тайланг гарган мэдээлэхээр бэлтгэж байна. (Хэрэгжих шатанд - 70%)
Арга хэмжээ 4.10.7 (88) “Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв”-д иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг барагдуулах, шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - Өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч удирдлагын заалтын дагуу холбогдох албан хаагчид шилжүүлэх; - Хугацаанд нь шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулах; - Шийдвэрлэлтийг “Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв”-д хүргүүлэх; - Жилдээ. 	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдана.	ЗХЗХ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт Засгийн газрын “Иргэд, олон нийттэй харилцах төв”-өөр дамжуулан 2019 оны эхний хагас жилд төрийн худалдан авах ажиллагааны цахим системтэй холбоотой 3, худалдан авах ажиллагаатай холбоотой 1, орон сууц хувьчлалтай холбоотой 1, газрын цахим хуудастай холбоотой 1, нийт 6 санал, хүсэлт, гомдлыг иргэдээс ирүүлснийг хүлээн авч, бүртгэлд хамруулан хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу өгөв. Тайлант хугацаанд, дээр дурдсан өргөдөл, гомдлыг шуурхай нягтлан шалгаж, асуудлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн ба дутагдал гаргасан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох нөхцөл үүссэн тохиолдол гараагүй. (Бүрэн хэрэгжсэн - 100%)
Арга хэмжээ 4.10.8 (89) Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн	<ul style="list-style-type: none"> - Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг ханган тухайн сарын холбогдох гүйлгээг хийх; - Албан хаагчдын цалинг 	Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг хууль, дүрэм, заавар, стандартын	ЗХЗХ	1.ТӨБЗГ-ын 2019 оны үйл ажиллагааны зардалд 1,505,074.60 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 2019 эхний хагас жилд 685,348.815 мянган төгрөгийн гүйцэтгэл гарч, 2019 оны сүүлийн хагас жилд 822,915.87 мянган төгрөгийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна. Төсвийн зардлын санхүүжилт:

хөтлөх	<p>цагийн бүртгэлд үндэслэн тооцож олгох;</p> <ul style="list-style-type: none"> - Цалин хөлсний тооцоолол, түүний мэдээллийг сар бүр албан хаагчдад хүргэж хэвших; - Үндсэн хөрөнгийн тооллогыг хагас, бүтэн жилд тусгай комисс байгуулан хийлгэж, үр дүнг тайлагнах; - Санхүүгийн тайланг сар, улирал, хагас, бүтэн жилээр гарган аудитын байгууллагаар баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх. 	дагуу хөтөлж, тайлагнасан байна.		<ul style="list-style-type: none"> - Цалин хөлс болон НДШ-д - 486.4 сая төгрөг; - Урсгал зардалд – 1.9 сая төгрөг; - Хангамж, материалын зардалд – 29.5 сая төгрөг; - Томилолтын зардалд – 15.3 сая төгрөг; - Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд – 147.4 сая төгрөг; - Бараа, үйлчилгээний бусад зардалд – 1.7 сая төгрөг; - Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулалд 3.0 сая төгрөг. <p>2.Албан хаагчдын цалинг хурууны хээний төхөөрөмж уншсан ирцийн мэдээлэл, ирцэд хийсэн үзлэг шалгалтын дүнд үндэслэн тооцож байна.</p> <p>3.2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/142 дугаар тушаалаар үндсэн хөрөнгийн тооллогыг зохион байгуулах үүрэг бүхий комисс байгуулагдан, тооллогыг 2019 оны 05 дугаар сарын 15-25-ны өдрүүдэд явуулав. ТӨБЗГ-ын балансад 2019 оны эхэнд 5,997,065,007.62 төгрөгийн балансын үнэ бүхий 1330 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байсан бөгөөд 2019 оны эхний хагас жилд газар, үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний 49,750,000.00 төгрөгийн үнэ бүхий программ балансад шинээр бүртгэгдэж, эхний хагас жилийн тооллогын дүнгээр 6,046,815,007.62 төгрөгийн балансын үнэ бүхий нийт 1331 ширхэг үндсэн хөрөнгө тоологдсон.</p> <p>4.2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хууль, журмаар тогтоосон хугацаанд Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэн, тайланг хамгаалж баталгаажуулсан. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны санхүүгийн гүйцэтгэл, Ерөнхий сайдын харьяа байгууллагуудын 2018 оны шилэн дансны хэрэгжилтэд Үндэсний аудитын газраас аудит хийсэн бөгөөд “Зөрчилгүй” дүгнэлт гарсан. (Бүрэн хэрэгжсэн - 100%)</p>
<p>Арга хэмжээ 4.10.9 (90)</p> <p>Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган холбогдох хуульд заасан мэдээллийг https://www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулан, ил тод байдлыг хангах</p>	<ul style="list-style-type: none"> - Төсвийн зарцуулалт, худалдан авалт, өмч хөрөнгө захиран зарцуулсан шийдвэр гэх мэт Шилэн дансны тухай хууль тогтоомжид заасан мэдээллийг https://www.shilendans.gov.mn цахим хуудсанд байршуулах; 	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, байгууллагын төсөв, санхүүгийн мэдээллийн ил тод байдал хангагдана.	3X3X	Байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, өмч хөрөнгө захиран зарцуулах шийдвэр, ашиг сонирхлын зөрчилтэй эсэх тухай мэдэгдэл, аудитын тайлан, дүгнэлт зөвлөмж зэрэг мэдээллийг Шилэн дансны тухай хууль, журмын дагуу шилэн дансны http://shilendans.gov.mn цахим системд сар бүрийн 08-ны өдрийн дотор байршуулан мэдээлж, санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан. Мөн байгууллагын мэдээллийн самбарт төсөв, санхүүгийн холбогдох мэдээллийг холбогдох хууль, журмын

	<ul style="list-style-type: none"> - Мэдээллийн самбарт санхүүгийн тайлан, мэдээллийг байршуулан мэдээлэх; - Тухай бүр. 			дагуу сар бүрийн 5-ны өдрийн дотор байршуулж, шинэчлэн мэдээлж байна. (Хэрэгжих шатанд - 70%)
<p>Арга хэмжээ 4.10.10 (91)</p> <p>2020 оны төсвийн төсөөллийг Сангийн яаманд хянуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Төсвийн төсөөлөлтэй холбоотой баримт материалыг бэлтгэх, төсвийн төсөл боловсруулах; - 2020 оны төсвийн төслийг Сангийн яам, Ерөнхий сайдын ажлын албанд хүргүүлэх; - III улиралд. 	2020 оны төсвийн төлөвлөлт хийгдэн, хянагдсан байна.	3Х3Х	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр орсон өөрчлөлтөөр худалдан авах ажиллагааны чиг үүрэг бүхий бие даасан байгууллага байгуулагдахаар болсон)-ын 2020 оны төсвийн төслийг тус тус Төсвийн тухай хуулийн 8.3.4 дүгээр зүйлд заасны дагуу 7 дугаар сарын 5-ны дотор Төсвийн ерөнхийлөн захирагч, Сангийн яаманд тус тус хүргүүлэхээр бэлтгэж байна. (Хэрэгжих шатанд - 70%)
<p>Арга хэмжээ 4.10.11 (92)</p> <p>Нийгмийн даатгалын тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээг гаргах</p>	<ul style="list-style-type: none"> - Холбогдох тайланг Нийгмийн даатгалын байгууллага, Ерөнхий сайдын Ажлын албанд хүргүүлэх; - Албан хаагчдын НДД, ЭМД-т бичилт хийж, баталгаажуулах; - Сар бүр. 	Нягтлан бодох бүртгэлийн хууль болон нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт шаардлагад нийцсэн тайлан тэнцлийг гаргаж, зохих хууль, журмын дагуу холбогдох байгууллагад хугацаанд нь хүргүүлсэн байна.	3Х3Х	<p>Байгууллагын албан хаагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг сар бүрийн 5-ны өдрийн дотор НД7, НД8 маягтын дагуу гарган нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэн баталгаажилт хийлгэв. Албан хаагчийн нийгмийн даатгалын дэвтэрт сар бүрийн 10-ны өдрийн дотор бичилт хийж байна.</p> <p>Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 49 тоот тушаалаар батлагдсан загварын дагуу төсвийн гүйцэтгэлийн зарлагын сарын мэдээг сар бүрийн 02-ны өдрийн дотор гарган Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэв. (Бүрэн хэрэгжсэн - 100%)</p>
<p>Арга хэмжээ 4.10.12 (93)</p> <p>Ашиглалтын хугацаа дууссан, чанарын шаардлага хангахгүй болсон хөрөнгийн жагсаалт гарган, байгууллагын эд хөрөнгийн бүртгэлийг</p>	<ul style="list-style-type: none"> - Ашиглалтын хугацаа дууссан, цаашид ашиглагдахгүй болсон эд хөрөнгийн жагсаалт гаргах; - Газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэр гаргуулах; - Эд хөрөнгийн бүртгэлээс хасч, холбогдох гүйлгээ 	Эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих боломж бүрдэнэ.	3Х3Х	Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн хурлаар 2019 онд хөрөнгө оруулалтаар авсан 296.2 сая төгрөгийн үнэ бүхий 15 нэрийн 87 ширхэг компьютер, техник хэрэгслийг балансад бүртгэх, ашиглалтын хугацаа дууссан, үлдэгдэл өртөггүй, ашиглах боломжгүй болсон 56.4 сая төгрөгийн балансын үнэ бүхий 160 ширхэг тавилга, эд хогшил, 27.6 сая төгрөгийн балансын үнэ бүхий 15 ширхэг компьютер, техник хэрэгслийг холбогдох заавар, журмын дагуу акталж, данснаас хасахаар шийдвэрлэсэн. Мөн ТӨБЗГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 163.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий 10-26 УНУ улсын дугаартай

шинэчлэх	<ul style="list-style-type: none"> хийж; - Албан хаагч бүрт эд хөрөнгийн бүртгэл, ашиглалтын картыг хөтөлж, хяналт тавих; - Эд хөрөнгийн тооллого, бүртгэлийг хийж, кодчиллыг шинэчлэх; - I сард. 			Ниссан патрул автомашиныг ТӨБЗГ-ын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 136 дугаар тогтоолоор Гаалийн ерөнхий газарт, 103.9 сая төгрөгийн балансын үнэ бүхий 15-35 УНУ улсын дугаартай Бенз Е-200 автомашиныг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 217 дугаар тогтоолоор Автотээврийн үндэсний төвд тус тус балансаас балансад шилжүүлсэн. (Хэрэгжих шатанд - 70%)
<p>Арга хэмжээ 4.10.13 (94)</p> <p>Байгууллагын үйл ажиллагааны хэвийн байдлыг хангахад шаардлагатай бараа, материалыг татан авч, хуваарилах</p>	<ul style="list-style-type: none"> - Хууль, журмын дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэгчтэй гэрээ байгуулах, I сард; - Гэрээний дагуу бичиг хэргийн хэрэгсэл, материалыг захиалах; - Шаардах хуудас, удирдлагын зөвшөөрөл, хяналтын дагуу албан хаагчид олгох; - Бараа, бүтээгдэхүүний төсөв, зардлын тооцоог хийж, хяналт тавих, сар бүр; - Жилдээ. 	Байгууллагын хэвийн үйл ажиллагаа хангагдана.	ЗХЗХ	<p>Байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг тасралтгүй явуулах нөөц боломжийг бүрдүүлэх хүрээнд “Говь таван элс” ХХК, “Гурван цагийн өнгө” ХХК, Архивын ерөнхий газар зэрэг байгууллагуудтай бараа, материал нийлүүлэх гэрээ байгуулан хамтран ажиллаж, 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар 20.2 сая төгрөгийн бараа, материал, шатахуун шинээр татан авч, бараа материалыг санхүү бүртгэлийн анхан шатны баримтын бүрдлийг ханган, удирдлагын зөвшөөрлийн дагуу 19.8 сая төгрөгийн бараа материал, шатахууныг олгосон байна.</p> <p>Мөн ТӨБЗГ-т шүүхийн шийдвэрээр шилжин ирсэн “Роял Грийн Вилла” хотхонд байрлах орон сууцыг түрээслэх зорилгоор “Ремакс” ХХК-тай “Үл хөдлөх хөрөнгийг түрээслэхэд зуучлах онцгой эрхийн тухай”-ийн 04/17 дугаар гэрээг, “Засгийн газрын авто бааз” УТҮГ-тай “Засвар үйлчилгээ авах тухай” 04/16 дугаар гэрээг, “Авто зогсоолын автомат хаалт суурилуулах тухай” 04/15 дугаар гэрээг “Мандал медиа” ХХК-тай, “Хувилах, олшруулах төхөөрөмжийн засварын ажил гүйцэтгэх тухай” 04/14 дүгээр гэрээг “Микр” ХХК-тай тус тус байгуулав. (Бүрэн хэрэгжсэн -100%)</p>
<p>Арга хэмжээ 4.10.14 (95)</p> <p>Албан хаагчдын дунд олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах</p>	<ul style="list-style-type: none"> - Олон нийтийн ажил зохион байгуулах комиссыг шинэчлэн байгуулах, I сард; - Ажлын төлөвлөгөө боловсруулах, батлах; - Төлөвлөгөөний дагуу олон нийтийн ажлыг зохион байгуулах, жилдээ. 	Албан хаагчийн чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрөөх, хамт олонч уур амьсгалыг бүрдүүлсэн байна.	ЗХЗХ, Олон нийтийн ажил зохион байгуулах комисс	<p>Байгууллагын Олон нийтийн ажил зохион байгуулах комиссоос Цагаан сарын баярыг тохиолдуулан 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ахмадуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх, 02 дугаар сарын 11-ний өдөр албан хаагчдын нэгдсэн золголт хийх, 05 дугаар сарын 30-ны өдөр “Хүүхдийн баяр”, 7 дугаар сарын 09-ний өдөр Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 98 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн арга хэмжээг тус тус зохион байгуулав.</p> <p>(Хэрэгжих шатанд - 70%)</p>
Нийт: 4 стратегийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 10 хөтөлбөр, 95 арга хэмжээ				

ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТАНИЛЦУУЛГА

(Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт арга хэмжээгээр)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 4 стратегийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 10 хөтөлбөр бүхий **95 арга хэмжээний** хэрэгжилтийг 2019 оны эхний хагас жилийн дүнгээр гарган дүгнэв. Хэрэгжилтийн явцын дүнгээс дүгнэхэд, 2019 онд төлөвлөсөн нийт 95 зорилт (арга хэмжээ)-ын хэрэгжилтийн явц дунджаар **74.3 хувийн** гүйцэтгэлтэй байна. Хэрэгжилтийн дүнг тооцохдоо Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан үнэлгээний аргачлалыг баримтлан дүгнэв.

Хэрэгжилтийн явцын дүн

Д/д	Хэрэгжилтийн явц (үнэлгээний хувь)	Заалтын тоо
1	Нийт хэрэгжүүлэх арга хэмжээ	95
2	Үүнээс: “Бүрэн хэрэгжсэн” – 100 %	29
3	“Хэрэгжих шатанд” – 70 %	49
4	“Хэрэгжилт хангалтгүй” – 30 %	7
5	“Хэрэгжээгүй” – 0 %	3
6	“Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”	7
7	Хэрэгжилтийн дундаж хувь (дундаж үнэлгээ) - 74.3 хувь.	

Танилцсан:

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН

АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

Хянасан:

ДЭД ДАРГА

А.ДАГВАДОРЖ

Нэгтгэн боловсруулсан:

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Х.ЭНХЧИМЭГ